



**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

/АЛБАН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛСАН ХУРААНГУЙ/

ХОЁР ДАХЬ ХЭВЛЭЛ

Улаанбаатар хот
2020 он

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

/Албан хэрэгцээнд зориулсан хураангуй/
Хоёр дахь хэвлэл

Хянасан: Ц.Ганхүү /ГЗБГЗЗГ-ын дарга бөгөөд ГШҮХ-ны нарийн бичгийн дарга/
Р.Ганхуяг /ГЗБГЗЗГ-ын Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга/
Ж.Батсайхан /ГЗБГЗЗГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга/
М.Хүрэлбаатар /ГЗБГЗЗГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн/

Эмхэтгэсэн:

Б.Дөл /ГЗБГЗЗГ-ын Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/
П.Гэрлээ /ГЗБГЗЗГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн/
Г.Намсрай /Төслийн багийн ахлагч/
Л.Мягмаржалбуу /Төслийн багийн ерөнхий зөвлөх/
Б.Түвшинтөр /Төслийн багийн мэргэжилтэн/

Эх бэлтгэсэн: Ш.Гантуул
Цаасны хэмжээ: 60x84/8
Хэвлэлийн хуудас: 31.25 х.х

“СОДПРЕСС” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

Улаанбаатар хот
2020 он



ӨМНӨХ ҮГ



ГАЗАР бол манай орны тусгаар тогтнолын баталгаа, ард түмний мэдэлд байх үнэт зүйл, төрийн онцгой өмч юм.

Төрөөс газрын талаар баримтлах нэгдсэн бодлого, нэгдсэн төлөвлөлт байхгүйгээс салбарууд тус тусдаа бодлого, үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг тогтолцоо манай улсад буй болсноор газар үнэ цэнээ алдаж, ард түмэн газраас хүртэх үр ашгийг хүртэж чадахгүй, томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжихгүй байна. Товчхон хэлбэл, газрын зохицуулалтгүй ашиглалтаас үүдэлтэй агаар, хөрс, усны бохирдол, хүн амын хэт төвлөрөл, замын түгжрэл, бэлчээрийн доройтол, цөлжилт, газрын маргаан зөрчил, ядуурал зэрэг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн олон асуудлууд үүссэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1-т “Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс

боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ” гэж, мөн 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.84-т “Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж заасны дагуу улсын хэмжээнд газрын нөхцөл, нөөц, даац, чадавх болон иргэн, улс орны хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн салбарын бүх яамд, агентлагууд хамтран Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсрууллаа.

Уг төлөвлөгөө нь эдийн засгийг төрөлжүүлэн улс орноо хөгжүүлэх, газар нутагтаа хүн амаа тархаан суурьшуулах, өрхийн аж ахуйг хөгжүүлэх, томоохон хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, уламжлалт бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослон эрхлэх, газар тариалан, аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх, уул уурхайн зүй зохистой ашиглалт, түүнээс байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, зам, харилцаа, дэд бүтэц, ойн болон усны сан бүхий газрын ашиглалт, хамгаалалт, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх зэрэг манай орны тогтвортой хөгжлийн бүхий л асуудлуудыг хамруулсан бөгөөд энэ нь газрын санг нэгдсэн бодлогоор удирдах, төлөвлөх, бүртгэх, үнэлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хянах үйл ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх боломжийг олгох юм.

Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг нь газар, байгалийн нөөцтэй холбоотой бүхий л салбарын суурь, бодлогын баримт бичиг байх ёстой бөгөөд салбарууд өөр хоорондоо уялдан зангидагдах гол нөхцөлийг бүрдүүлж байгаа учраас энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь Засгийн газар, яам, агентлагууд, орон нутгийн хамтын үүрэг мөн.

Энэхүү төлөвлөгөөг эрхлэн боловсруулсан Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон уг ажилд идэвхтэй оролцсон яам, агентлаг, орон нутгийн удирдлагууд, хамтран ажилласан эрдэмтэн, судлаач нар, гүйцэтгэгч байгууллагад талархал илэрхийлж, уг ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд нь амжилт хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 384

Улаанбаатар
хот

Улсын газар зохион байгуулалтын
ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Газрын тухай хуулийн 18.1.7, 25.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай:

а/ улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх газруудын байршил, хил зааг, хэмжээг газар дээр нь нарийвчлан тогтоож, газрын мэдээллийн санд бүртгэн олон нийтэд мэдээлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү), бүх шатны Засаг дарга нарт;

б/ аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулж, шинэчлэн батлуулах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллан газар зохион байгуулалтын зураг, схем, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусах хүртэлх хугацаанд улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ хэрэгжих газарт бусдад газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, энэ чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т;


в/ газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал тогтоох асуудлыг 2019 оны I улиралд багтаан Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, цаашид ангилал шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд;



г/ улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг салбар хооронд уялдуулан зохицуулахыг Газрын шинэтгэлийн үндэсний хороо (Ө.Энхтүвшин)-нд;

4. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Ерөнхий төлөвлөгөө батлах тухай” (Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө) Засгийн газрын 2003 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 264 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Барилга, хот байгуулалтын сайд

У.ХҮРЭЛСҮХ

Х.БАДЕЛХАН



Засгийн газрын 2018 оны 384 дүгээр
тогтоолын хавсралт

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

Нэг. Бичиглэлийн материал:

I боть. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ерөнхий хэсэг	193 хуудас
II боть. Бүрэлдэхүүн хэсэг-1: Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлага, хөдөө аж ахуйн газрын улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	330 хуудас
III боть. Бүрэлдэхүүн хэсэг-2: Хотжилт, хот, суурин, үйлдвэр, уурхайн хөгжлийн чиг хандлага, хот тосгон, бусад суурины газрын улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	354 хуудас
IV боть. Бүрэлдэхүүн хэсэг-3: Аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлага, аялал жуулчлалын бүс нутгийн улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	129 хуудас
V боть. Бүрэлдэхүүн хэсэг-4: Дэд бүтцийн хөгжлийн чиг хандлага, зам, шугам сүлжээний газрын улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	187 хуудас
VI боть. Бүрэлдэхүүн хэсэг-5: Ойн салбарын хөгжлийн чиг хандлага, ойн сан бүхий газрын улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	64 хуудас
VII боть. Бүрэлдэхүүн хэсэг-6: Усны салбарын хөгжлийн чиг хандлага, усны сан бүхий газрын улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	112 хуудас
VIII боть. Улсын тусгай хэрэгцээний газрын улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	115 хуудас

Хоёр. Зураглалын материал:

1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн схем зураг бүхий каталоги	87 хуудас
2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний байр зүйн зураг M1: 2 000 000	10 ширхэг



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааны 23 дугаар тэмдэглэлд:

"XIII.1. Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн 2019 оны явцын тайлангийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний мэдээллийн сангийн мэдээлэлд өөрчлөлт, шинэчлэлт оруулах, нарийвчлах зайлшгүй шаардлагатай тохиолдолд Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хандан зохих журмын дагуу шийдвэрлүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт даалгав.

2. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг нийцүүлэн боловсруулах, шинэчлэн батлуулах ажлыг эрчимжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



Товчилсон үгийн тайлбар


АДХГЗ	Ардын Депутатын Хурлын Гүйцэтгэх захиргаа
АЖ	Аялал жуулчлал
АИХ	Ардын Их Хурал
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
БЗД	Баянзүрх дүүрэг
БНБД	Барилгын норм ба дүрэм
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГЗБ	Газар зохион байгуулалт
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
ГНС	Газрын нэгдмэл сан
ГНСТ	Газрын нэгдмэл сангийн тайлан
ДГ	Дархан газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДНГ	Байгалийн нөөц газар
ДЦГ	Дархан цаазат газар
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЗГ	Засгийн газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИНД	Иргэний нисэхийн дүрэм
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ПГХ	Палеонтологи, геологийн хүрээлэн
САА	Сангийн аж ахуй
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УЦС	Усан цахилгаан станц
ҮХ Г	Үндэсний хөгжлийн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭАА	Хувиараа эрхлэх аж ахуй
ШУА	Шинжлэх Ухааны Академи
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ГАРЧИГ

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХЭРЭГЦЭЭ ҮНДЭСЛЭЛ, АЧ ХОЛБОГДОЛ	11
УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	21
1. ХАА-н газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ	24
2. Хот тосгон, бусад суурин газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ	54
3. Аялал рекреацийн нөөц бүхий газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ	96
4. Зам, шугам сүлжээний газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ.....	120
5. Ойн сан бүхий газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ.....	154
6. Усны сан бүхий газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ	168
7. Улсын тусгай хэрэгцээний газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ	184
УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНҮҮД	217





УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮЕИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ, ХЭРЭГЦЭЭ ҮНДЭСЛЭЛ, АЧ ХОЛБОГДОЛ

УГЗБЕТ-Г ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн ерөнхий байдал


Байгалийн нөөцийн хэрэгцээ өсөн нэмэгдэхийн сацуу аж үйлдвэржилт болон хотжилт асар хурдацтай явагдаж байгаа нь газар ашиглалт, хүн амын суурьшлын бүтцэд өөрчлөлт бий болгож, усны нөөц багасах, чанар муудах, биологийн олон янз байдал алдагдах, ой мод устгах, цөлжилт үүсэх, бохирдлын түвшин нэмэгдэх, улмаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг олон үр дагаврыг дагуулж байна. Хүн ам хэт нягтаршиж, хот байгуулалт, дэд бүтцэд шаардлагатай газрын хэрэгцээ ихсэхийн хирээр нутгийн уугуул иргэд зэрэг эмзэг бүлгийнхэнд тусах сөрөг нөлөө ихсэж байна.

Дэлхий нийтийн практикт газрын харилцааны асуудлыг шийдвэрлэхдээ нутгийн уугуул иргэдийн нэр төр, тэдний эрх, амьдралын хэв маяг, амьжиргааны тогтолцоо, соёл, уугуул нутаг, дундын өмч хөрөнгө, байгалийн болон соёлын өв бүхий газрын газар зохион байгуулалтыг тэдний оролцоо, эрх ашигт нийцүүлэх хандлага түгээмэл шинжтэй болж байна. Манай улсад нийтийн эзэмшлийн харилцаагаар зохицуулдаг газар, байгалийн нөөц баялаг бүхий газар нутгийн ерөнхий хил заагийг тогтоох, тэгш, шударга хуваарилалт, хүрэлцээний асуудал орхигдох хандлагатай болж байна.

Монгол Улс 1990 онд ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэний дараах хэсэг хугацаанд хүн амын амьжиргааны түвшин огцом доройтож, ДНБ 1990 онд 2.2 их наяд төгрөг байсан бол 1993 онд 1.8 их наяд төгрөг (2005 оны зэрэгцүүлэх үнээр) болон буурч, 1994 оны эцэс хүртэл ДНБ-ий өсөлт -4.4% байв. Нэг хүнд ногдох ДНБ 1990 онд 1,047,500 төгрөг байсан бол 1993 он гэхэд 825,300 төгрөгт (2005 оны зэрэгцүүлэх үнээр) хүрсэн нь нэг хүнд ногдох ДНБ-ий хамгийн доод хувь хэмжээ байлаа. 1992 онд инфляц гурван оронтой тоонд буюу 325.5%-д хүрсэн байна.

Харин 1995 оноос эхлэн эдийн засаг аажмаар сэргэж, удаан боловч тогтвортойгоор өсөж эхэлсэн бөгөөд 2003 онд нэг хүнд ногдох ДНБ 1990 оны түвшинд эргэж хүрчээ. Монголын эдийн засаг 2000-2009 онд жилд дунджаар зургаан хувиар өссөн нь энэ үед Монгол Улс ашигт малтмалын хэд хэдэн томоохон ордыг ашиглалтад оруулсантай холбоотой юм. Алт, зэсийн асар том орд болох Оюу толгойн бүтээн байгуулалт 2010 онд эхэлснээр өсөлтийн оргил үе эхэлсэн бөгөөд судлаачдын тооцоолсноор энэ орд нь 2020 он гэхэд Монгол Улсын ДНБ-ий гуравны нэг хүртэлх хувийг дангаар бүрдүүлэх боломжтой юм.

Зураг 1. Монгол Улсын эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ 1990-2014



Эх сурвалж: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд, 2015

Монгол Улсын экспортын нийт дүн 2000-2012 оны хооронд 10 дахин өссөн бол эрдэс баялгийн салбарын нийт экспортод эзлэх дүн 10 хувиас 89 хувь хүртэл өсөж, эдийн засгийн уул уурхайгаас хараат байдлыг улам бүр нэмэгдүүлж байна.


Эдийн засгийн өсөлтийн үед ядуурлын түвшин дорвитой буурч, 2010 онд нийт хүн амын 39 хувь нь ядуурлын шугамын дор байсан бол 2014 онд энэ үзүүлэлт 22 хувь, 2016 онд 29.2 хувь тус тус хүрчээ.

Монголын эдийн засаг 2005-2014 оны хооронд жилд дунджаар 9.9 хувиар өсч байсны гол хөдөлгүүр хүч нь уул уурхай, ялангуяа зэс, нүүрсний салбар байв. Эдийн засаг ийнхүү тэлэхэд гадаадын шууд хөрөнгө оруулалт голлох нөлөө үзүүлж, 2011 оны байдлаар ДНБ-ий 45%-тай тэнцэх хүртлээ өсжээ. Уул уурхай Монголын эдийн засагт зонхилох салбар болсноор нийт экспортын 89%-ийг бүрдүүлж, экспортын 89%-ийг БНХАУ руу гаргаж байв. Хэдийгээр энэ үед ядуурал буурч, нэг хүнд ногдох орлогын хэмжээ өсөж байсан ч уул уурхайн салбараас хэт хамааралтай болж, зөвхөн нэг түнштэй их хэмжээний худалдаа хийж байснаас гадна бусад салбар төрөлжөөгүйн улмаас Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдал нэмэгдэж, гадаад зах зээлийн гэнэтийн цочрол, өөрчлөлтөд өртөмтгий болсон.

ДНБ-ний хэмжээг голлох салбараар авч үзвэл 2016 оны байдлаар уул уурхай, үйлчилгээний бусад салбар дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь эдийн засгийн хөгжил салбараар жигд биш "солонгорч" чадаагүйг харуулж байна.

2000 онд хөдөөгийн бүс, Улаанбаатарын бүсийн ДНБ бараг тэнцүү байсан бол 2016 онд Улаанбаатарын бүсэд ДНБ-ий үйлдвэрлэл 2 дахин их байгаа бөгөөд энэ нь үйлдвэрлэлийн хэт төвлөрөл үүсэж хот хөдөөгийн ялгаа ихсэж бүсчилсэн хөгжлийн бодлого алдагдсан байгааг харуулж байна.

Зураг 2. ДНБ-ний үйлдвэрлэлийн график.сая төг /эдийн засгийн бүсүүдээр/ 2016 он



Монгол Улсын байгаль орчин, экологийн ерөнхий нөхцөл байдал*


Дэлхийн дулаарлын нөлөө манай оронд эрчимтэй ажиглагдаж цаг уурын байнгын ажиглалтын мэдээгээр агаарын дундаж температур сүүлийн 70 гаруй жилд 2,2°C-аар нэмэгдэж, хур тунадасны хэмжээ бага зэрэг буурсан байна. Монгол Улсын хүлэмжийн хийн нийт ялгарлын хэмжээ дэлхийн дунджаас бага боловч нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаралт нь 2014 оны байдлаар 6,08 тонн CO₂-эquiv байгаа нь дэлхийн дунджаас харьцангуй өндөр байна. Манай орны байгаль, нийгэм, эдийн засгийн салбарын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээний дүнгээр мал аж ахуй, газар тариалан, ойн аж ахуйн салбарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэх хандлагатай байна. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн зохисгүй ашиглалт, уул уурхайн үйл ажиллагаа зэргээс үүдэлтэй газрын доройтол, цөлжилт эрчимтэй явагдаж нийт нутаг дэвсгэрийн 76.8% цөлжилтөд өртсөн байна.




2015 оны цөлжилтийн нэгдсэн үнэлгээний дүнг өмнөх 2006 болон 2010 оны дүнтэй харьцуулж үзвэл цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэл бүхий газруудын тархац нутаг нэлээд өөрчлөгдсөн буюу ялангуяа нэн хүчтэй зэрэглэл бүхий газрууд шинээр голомтлон үүссэн байна.

Сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт үзэгдэл, үүний дотор ус цаг уурын аюултай болон гамшигт үзэгдлийн давтагдал ихсэж байгааг дэлхийн цаг агаарын дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй холбон тайлбарлаж байна. Тухайлбал, агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн тоо ихсэж, 1990-2000 онд жилд дунджаар 30 орчим аюултай үзэгдэл ажиглагддаг байсан бол 2001-2016 онд даруй 2 дахин нэмэгджээ.



Зураг 3. Монгол оронд ажиглагдсан ус, цаг уурын аюултай болон гамшигт үзэгдлийн тоо



Агаар дахь азотын давхар эслийн жилийн дундаж агууламж



Агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж



/*Эх сурвалж: Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2016 он/



Сүүлийн жилүүдэд хот, суурин газрын хүн ам, автомашины тоо ихээхэн өсөж, үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэхийн хирээр агаар, хөрс, усны бохирдлын түвшин зөвшөөрөгдөх хэмжээнээс давах тохиолдол тогтмол гарах болжээ. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж хүлцэх хэмжээнээс 2015 онд 2.4 дахин, 2016 онд 3 дахин их гарчээ. Орон нутгийн хэмжээнд авч үзвэл Баянхонгор, Даланзадгадад хүлцэх агууламжаас 1,6-1,8 дахин их байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуваарь, засаг захиргааны нэгжийн газар зохион байгуулалт, газрын нөөц, нэгдмэл сангийн удирдлагын тогтолцооны өнөөгийн байдал

Нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтыг нийгэм-улс төр, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс байнга хийдэггүй бөгөөд зөвхөн нийгэм-улс төр, төрийн байгууламж, өмчийн харилцаа, төсөв-эдийн засгийн бүтэц, тогтолцоонд өөрчлөн байгуулалт хийх зайлшгүй нөхцөл байдал үүссэн үед улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийг хэмжээнд нэгдсэн бодлогоор зохицуулж хийдэг.

Монгол улсын нутаг дэвсгэрийн хэлбэр нь төрийн удирдлагыг хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэхэд хэт сунаж тогтсон, хүн ам, газрын хэмжээ нь хэт харилцан адилгүй, бүс нутаг дахь нөөцийн хүртээмж, эдийн засгийн өгөөжийг тэгш хүртэх боломжийг хязгаарласан, нутаг дэвсгэр нь дундуураа өөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрээр тусгаарлагдаж тасарсан (устранение чересполосицы и других неудобств территории; the elimination of farming and other inconveniences territory) зэрэг сөрөг нөхцөл байдлыг арилгах үүднээс тодорхой бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хооронд нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтыг гүйцэтгэдэг.

Монгол Улсад нэгдэлжих хөдөлгөөн өрнөж нэгдэл, сангийн аж ахуйнууд эрчимтэй байгуулагдах цаг үетэй давхцуулан тэдгээрийн эдийн засгийн бааз суурь, уламжлалт нутаг дэвсгэрийн хуваарилалтад тулгуурлан нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын ажлыг 1959-1975 онуудад аж ахуй хоорондын газар зохион байгуулалтын хүрээнд явуулж ирсэн.

1990-ээд онд шинэ үндсэн хууль батлагдсаны дараа орон нутгийн хотын статустай байсан аймгийн төвүүд сумын статустай болсон ба ХАА-н нэгдэл, улсын сангийн аж ахуйн эдийн засгийн тогтолцоо, зохион байгуулалт, үйлчилгээнд суурилсан сумын нутаг дэвсгэрийн хуваарилалт, бүтэц, тогтолцоо бараг хэвээр хадгалагдан үлдсэн байна. Төрийн эрх барих дээд байгууллага (АИХ, УИХ) нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг 21 аймаг, нийслэл, 330 сум, 9 дүүрэгт хуваарилан хил заагийг баталж эзэмшүүлсэн.

Өнөөгийн байдлаар нутаг дэвсгэрийн өргөжүүлэх боломж муутай 9 аймгийн төв, УБ хотын суурьшлын бүсийг эхний ээлжид дахин төлөвлөлтөд оруулж газрыг шинэчлэн зохион байгуулах зайлшгүй шаардлагатай болоод байна.

Монгол улсын нутаг дэвсгэрийн хөгжил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн газар зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд:

1. Өмнөх нийгмийн үеийн улс орны бие даасан байдал, хувь хүний үзэл бодол, үйл ажиллагаанд байнга хяналт тавьж байх аймаг, сум, бригадын тогтолцооны хэт нягтрал үүсгэсэн, төсөв, хөрөнгө оруулалтын бие даасан байдлыг хангах боломжгүй, баг жалгаараа улс төрждөг, нутаг ус, төрөл садангаараа бүлэрхэх жалга довын үзлийг өөгшүүлсэн, иргэдийн оролцоог хангалтгүй, цус ойртолтын гол нөхцөл болсон Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, бүтэц зохион байгуулалтыг эргэн харж дээр дурдсан зохисгүй хандлагыг арилгах захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, бүтэц зохион байгуулалтыг бий болгох, Үндсэн хуулийн шаардлагад нийцсэн төрийн байгууламжийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.
2. Нутаг дэвсгэрийн хөгжилд эдийн засгийн газар зүй байршил, геополитикийн онцгой ач холбогдол бүхий газар нутаг, байгалийн нөөцийн чадавх, хэмжээ, хүний ур



чадвар, дэд бүтцийн хөгжил голлох нөлөөтэй байгааг харгалзан, үндэсний эдийн засаг, нийгмийн томоохон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагад үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг оновчтой, үр ашигтай болгох газар зохион байгуулалт хийх шаардлагатай байна.

3. Эрдэс баялаг болон байгалийн бусад нөөцийн ашиглалтад гарч буй шийдвэрлэгдээгүй томоохон маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд Засгийн газар, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд газрын дээрх болон доорх баялгийн тогтоогдсон нөөц, тухайн газраа эд хөрөнгийн хэлбэрт шилжүүлж үнэлэн өмч эд хөрөнгийн хэлбэрт шилжүүлж хэлцлийн зүйл, газар, газрын эрх, эрдэс түүхийг эдээр/Land consolidation/ тохиролцож хөрөнгө оруулалтыг татах, газраа түрээсийн ашиглалт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, нөхөн олговор, төлбөр, газарт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн механизм, арга хэрэгсэл болгох замаар төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрдүүлэх тогтолцоонд шилжих шаардлагатай байна.

Үндэслэл


Аливаа улс орон хэтийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиг хандлагаа тодорхойлж газар, нутгаа хөгжүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалах төлөвлөгөөтэй байдгийн адилаар Монгол Улсын “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г анх Засгийн газрын 2003 оны 264 дүгээр тогтоолоор батлагдсанаас хойш “Газрын тухай хууль”-д 64 заалтад нэмэлт, өөрчлөлт орсон, Газрын харилцаатай холбоотой 7 хууль шинээр болон шинэчлэн найруулагдсан, газар зохион байгуулалттай ямар нэг байдлаар холбоотой 50 хөтөлбөр, бодлого, хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгүүд шинээр батлагдсан, мөн газар ашиглалтын тохиромжтой байдлын болон хэрэгцээт байдлын үнэлгээг шинээр хэрэглэх шаардлага гарсан болно.

Үндсэн зорилго

Газрын нөөц, нэгдмэл сангийн иж бүрэн мэдээлэл, судалгаа, шинжилгээ, нийгэм, эдийн засгийн бусад мэдээлэлд үндэслэсэн газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон нийгмийн хэрэгцээнд тэгш, шударга, хүртээмжтэй байдлаар хуваарилах замаар эрх зүйн болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экологийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалт, газрын кадастрыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглах, үйлдвэрлэлийн салбаруудыг зөв байршуулж төрөлжүүлэн хөгжүүлэх, **“Монгол Улсын тогтвортой хөгжил-2030”**-ийг хэрэгжүүлэхэд газрыг менежментийн бодлогоор дэмжих суурь үндэслэлийг бий болгоход “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-ний үндсэн зорилго оршино.



Тогтвортой хөгжлийн хүрээ, агуулгын зураг




Баримталсан зарчим

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангасан байх;
- Салбар хоорондын уялдаа, тэдгээрийн өрсөлдөх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн байх;
- Байгалийн нөөц, үйлдвэрлэлүүдийн эргэх холбоог хангасан байх;
- Улс орны хөгжлийн эрх ашиг, сонирхлоор эрэмбэлэх;
- Үйлдвэрлэлүүдийг төрөлжүүлсэн байх;
- Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах;
- Төсөв, хөрөнгө, цаг хугацааг хэмнэсэн байх;
- Маркетингийн бодлого, стратегид суурилсан байх.

УГЗБЕТ-ний стратеги: УГЗБЕТ-ний стратеги нь нийгэм, экологи, эрх зүйн агуулга, чадамж сул, салбар хоорондын уялдаа, инженер-эдийн засгийн тооцоолол, шийдэл муутай зөвхөн орон зайг тодорхойлсон солбицол, талбайн хэмжээгээр хязгаарласан сэдэвчилсэн зургийн агуулгаар хязгаарласан, цогц биш газар зохион байгуулалтын өнөөгийн төлөвлөлтөөс газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, газрын хэрэгцээ, байгалийн болон бусад нөөцийн ашиглалтын оновчтой байршилд нийцүүлэн газрын нэгдсэн, цогц бодлого төлөвлөлтийн шийдэл бүхий эрх, эдийн засаг, экологийн цогц агуулгатай газар зохион байгуулалтын төлөвлөлтийн тогтолцоонд шилжихэд чиглэгдэж байна.



УГЗБЕТ-ний газрын нөөц, нэгдмэл сангийн удирдлага, төлөвлөлтийн стратегийн схем зураг



Стратегийн зорилт 1. Төрөөс газар, байгалийн нөөцийн хүртээмж муутай хуваарилалт, иргэд, олон нийт, нийгмийн хэрэгцээнд хүртэх үр ашиг багатай, тэгш, шударга биш хуваарилалтын системээс газар, байгалийн нөөцийг иргэд олон нийтэд тэгш шударга хүртээмжтэй хуваарилах, өмчлүүлэх, зах зээлийн арга хэрэгсэл, механизмуудыг нэвтрүүлж, тогтвортой хөгжлийг хангах газрын нөөц, нэгдмэл сангийн удирдлага, төлөвлөлтийн системд шилжинэ.

Стратегийн зорилт 2. Газрын тухай хууль тогтоомж нь хөгжлийн үйл явц, цаг үеийн шаардлагаас хоцорч нийгэм, эдийн засгийн суурь харилцааг зохицуулахад хүндрэлтэй болсон өнөөгийн газрын харилцааны хууль, эрх зүйн орчноос улс орны хөгжлийн хэрэгцээг хангаж чадахуйц газрын харилцааны хууль эрх зүйн орчинд шилжих, улмаар нийгмийн харилцааны хувьсал, өөрчлөлтийг урьдчилан харж газрын тухай хууль тогтоомж бусад баримт бичгийг цаг алдалгүй боловсронгуй болгож байх газрын харилцаа, газар зохион байгуулалтын салбарын үр дүнг хэмжих, хянах мониторинг, үнэлгээ хийх төрийн захиргаа, удирдлагын чадавхыг бүрдүүлнэ.

Стратегийн зорилт 3. Газрын сан нэгдмэл байх төрийн бодлого, зарчмыг алдагдуулсан, газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, шалгуурт нийцүүлээгүй өнөөгийн газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын нөөц, нэгдмэл сангийн удирдлага, хуваарилалтын олон эрх мэдэл бүхий төрийн институцийн тогтолцооноос нэг байгууллагад нэгтгэн зангидсан, тогтвортой хөгжлийн шалгуурт нийцсэн, хүний үндсэн эрхийг хангах, хамгаалах, иргэдийн оролцоо, хүртээмжийн хангасан, салбаруудын газрын хэрэгцээ, зохистой харьцааны тэнцвэрийг хангах чадамжтай, газар ашиглалтын нийгэм, экологи, эдийн засгийн

үр ашгийн шалгуур бүхий газар зохион байгуулалтын төлөвлөлтийн үндэсний нэгдсэн систем, удирдлагын тогтолцоонд шилжих.

Ингэхдээ нийгэм, эдийн засгийн агуулгатай газар зохион байгуулалтыг хөгжүүлэхийн тулд Газрын тухай хуулийн 25.2-т “нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх” гэсэн агуулга бүхий заалтын хүрээнд түүхий эдийн экспорт, гадаад орнуудын өртөг нэмсэн бүтээгдэхүүний импортын хэрэглээнд түшиглэсэн эдийн засгаас газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, нөөцүүдийн байршилд нийцүүлэн үйлдвэрлэл, эдийн засгийн салбарын төрөлжүүлэн байршуулж, өртөг нэмсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх эдийн засаг-нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн тогтолцоонд шилжинэ.

Стратегийн зорилт 4. Газар, байгалийн нөөцийг эд хөрөнгийн хэлбэрт шилжүүлж зах зээлийн сонгодог утгаар эдийн засгийн эргэлтэд оруулах, хөрөнгө оруулалт, төсвийн орлогын тогтвортой эх үүсвэр, актив болгох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд салбаруудын “өмчирхсөн” уялдаа муутай газрын эрх зүйн кадастрын тогтолцооноос үл хөдлөх хөрөнгийн эдийн засаг (real estate economics, нөөцийн (resource economy) болон фискаль эдийн засаг (fiscal economics) суурилсан газар, нөөцийн үнэлгээ, газрын улсын нэгдсэн бүртгэлийн систем (a unified system of land registration) бүхий олон улсын жишигт нийцсэн кадастрын үндэсний нэгдсэн систем, удирдлагын тогтолцоонд шилжинэ.

Стратегийн зорилт 5. УБ хотын хэт төвлөрөл, зохион байгуулалт муутай нутагшил, суурьшилт түүнээс үүдэлтэй утаа, агаар, хөрс, усны бохирдлын аюултай өнөөгийн нөхцөл байдлаас гарч бусад бүсүүдэд зохистой төвлөрлийг үүсгэхийн тулд иргэдийн өмчийн газар, бусад үл хөдлөх хөрөнгөтэй болгох ажлыг орон сууцны доорх болон СӨХ-ын газар, малчдын өвөлжөөний газрыг өмчлүүлэх, нийгэм-эдийн засгийн уялдаа холбоо, газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн бүс нутгуудад эдийн засаг, үйлдвэрлэлийн салбаруудыг оновчтой байршуулж кластераар хөгжүүлж ажилгүйдэл ядуурлыг бууруулах, бүс нутгуудад уур амьсгалын өөрчлөлт, экологийн даацад зохицсон үйлдвэрлэл, нутагшил, суурьшлыг тогтолцоог бүрдүүлж ХАА-н тогтвортой хөгжлийг хангана.

Стратегийн зорилт 6. Газар, бэлчээр, ус, ой, ашигт малтмалын нөөцийн ашиглалт, хамгаалалтын салангид уялдаа муутай менежмент, төлөвлөлтөөс уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, цөлжилтийн үйл явцын эрсдэлийг хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулж газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн байгалийн нөөцийн нэгдсэн менежмент, газар-ус-ойн оновчтой, зүй зохистой, үр ашигтай, цогц, нэгдсэн (rational, optimal and efficient integrated planning of land, water and forest use) бодлого төлөвлөлт, газрын төлөв байдалд тавих төрийн хяналт, мониторингийн нэгдсэн тогтолцоонд шилжинэ.

Стратегийн зорилт 7. Ил тод нээлттэй бус, техник, технологийн хувьд иргэд, олон нийт мэдээлэл авахад бэрхшээлтэй өнөөгийн газрын мэдээллийн менежментээс инновацад суурилсан орчин үеийн цахим технологи, автоматжуулалт, программ хангамж бүхий иргэн, олон нийтэд нээлттэй, ил тод газрын мэдээллийн менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

Тэргүүлэх ач холбогдол:

УГЗБЕТ-нд салбар хоорондын газрын нөөцийн хуваарилалт, гүйцэтгэх үүрэг, салбаруудын эдийн засаг, аж ахуйн төрөлжилтийн бүсчлэл, байршлын оновчтой шийдлийг тогтооходоо газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ, нөөцийн байршил, хэмжээнд тэргүүлэх ач холбогдол өгч төлөвлөсөн

Улсын ГЗБЕТ-ний шийдэл нь уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаварт дасан зохицох, өөрчлөлт, нөлөөллийг тогтоон барих, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, амьдралын чанар, экосистемийн тэнцвэр, байгаль хамгаалалд тэргүүлэх ач холбогдол өгч төлөвлөсөн.



Суурин хөдөө аж ахуйг хөгжүүлэх хүрээнд газар тариалан, жимс жимсгэнэ, гахай шувуу зэрэг аж ахуй эрхлэхэд УБ хотоос хөдөө орон нутагт гэрээгээр шилжих айл өрх, орон нутгийн орлого багатай айл өрх, хоршоо, нөхөрлөлд Газрын тухай хуулийн 4.1.3-т “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах” гэж заасны дагуу хүртээмжтэй байдлаар газрыг хуваарилахад тэргүүлэх ач холбогдол өгч төлөвлөсөн

Өөрийн орны газар зүйн байршлын давуу тал, газар нутгийн экологийн цэвэр байдлыг харгалзан органик, экологийн цэвэр бүтээгдэхүүний экспортыг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлд тэргүүлэх ач холбогдол өгч төлөвлөсөн

Газар зүйн орон зайн байршил, нөөцийн хүчин зүйлд үндэслэн түүхий эд нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын өртгийн сүлжээний цогц уялдааг хангасан кластерын зарчмаар хөгжих тогтолцоог бүрдүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгч төлөвлөсөн.



УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
/Газрын нэгдмэл сангийн ангиллаар/




Таних тэмдэг

- Аймгийн төв
- Сумын төв
- Улсын хил
- Аймгийн хил
- Нуур
- Тариалангийн газар
- Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар
- Хадлангийн газар
- Аймаг дундын отрын бүс нутаг
- Халхгол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн хил


Төлөвлөж буй ХАА-н агропарк

- | | | | |
|--|---------------------|--|-----------------------------------------|
| | Мах-сүүний АГРОПАРК | | Шувууны АГРОПАРК |
| | Сүү-Махны АГРОПАРК | | Таримал ургамлын үр үржүүлгийн АГРОПАРК |
| | Махны АГРОПАРК | | Хүнсний ногооны АГРОПАРК |
| | Сүүний АГРОПАРК | | Тэжээлийн АГРОПАРК |
| | Гахайн АГРОПАРК | | Жимс жимсгэний АГРОПАРК |
| | | | Хүлэмжийн АГРОПАРК |

ХАА-н усан хангамжийг сайжруулах судалгаа хийх газрын схем




- ХАА-н усан хангамжийг сайжруулах чиглэлээр судалгаа хийхээр төлөвлөж буй арга хэмжээ**
- Гол, мөрний болон шар усны уерийн ус хуримтлуулах сан байгуулах боломжтой судалгаа хийхээр төлөвлөж буй газрын байршил
 - Усан цахилгаан станц болон усан сан байгуулах боломжтой судалгаа хийх газрууд
 - Усны судалгаа хийхээр төлөвлөж буй газар тариалан, суурин АА-н бүс
 - 5000-с дээш га талбайтай хөв байгуулах боломжтой судалгаа хийхээр төлөвлөж буй газар
 - 5000-2000га талбайтай хөв байгуулах боломжтой судалгаа хийхээр төлөвлөж буй газар
 - Усжуулахаар төлөвлөж буй бэлчээр




- Хадланд тохиромжтой байдлын үнэлгээ /ургацын хэмжээгээр/**
- Тохиромжтой /ургац бцн.га-с дээш/
 - Хадаж болох бэлчээр /ургац 4-6цн.га/

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018 - 2025 он/


Хөдөө аж ахуйн газрын УГЗБЕТ-ний схем зураг



Хадлангийн газрын хайгуул, судалгаа, ГЗБ хийх газрын схем



Атар газрын эрэл хайгуул судалгаа, ГЗБ хийх газрын байршлын схем



- Одоогийн газар тариалангийн бүс
- Атар газрын хайгуул судалгаа, ГЗБ хийх бүс

1. ХАА-н газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ

ГАЗАР ТАРИАЛАН, СУУРИН АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Төлөвлөсөн суурин ХАА-н бүс нутагт эрчимжсэн мал амьтны аж ахуй, газар тариалан, уламжлалт нүүдлийн мал аж ахуй хоорондын хил зааг тогтоох газар зохион байгуулалтын цогц арга хэмжээг* хэрэгжүүлэхээс гадна бусад нутаг дэвсгэрт тархай, жижиг байршил бүхий суурин ХАА-д тохиромжтой газар нутгуудад өрхийн аж ахуй, хот айл, жижиг фермер, хоршоо, нөхөрлөлийн хэрэгцээний тариалан, атаршсан газар, таримал бэлчээр, хадланд ашиглах газрын хайгуул, судалгаа хийж ГЗБ-ын мэргэжлийн байгууллагын хээрийн судалгааны экспидеци ажиллуулж судалгаа хийх, ГЗБ-ын ажлын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн тариаланд тохиромжтой газрын цаашдын ашиглалт, хамгаалалтын зориулалтыг тогтоох, төлөвлөх, ГЗБ-ын ажил гүйцэтгэх хэрэгцээ шаардлагыг үндэслэж дараах байдлаар бүс газрын схемийг боловсруулав.

1. Газрын тухай хуулийн 9.2, Тариалангийн тухай хуулийн 17.1, 24.2-д заасны дагуу одоогийн байгаа тариалан болон атаршсан газар буюу бүс газрын схем;

2. Газрын тухай хуулийн 16.1.13, 23.2.15, 25.1.5, 54.1, 52.4-д заасны дагуу ГЗБ, хайгуул судалгаа, шинжилгээний ажил хийж зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж суурин аж ахуй хөгжүүлэх бүтээн байгуулалт хийх бүс газрын схем;

Тариаланд тохиромжтой газарт ургамлын аж ахуйгаас гадна, өндөр ашиг шимт эрчимжсэн мал, амьтны аж ахуй (гахай, шувуу, зөгий, загас, үслэг ан зэрэг) эрхлэх үндсэн зориулалттай газар байхаар төлөвлөв.

Одоогийн тариалан болон хуучин хагалсан газрын тохиромжтой байдал, га

Аймгийн нэр	Нэн тохиромжгүй	Тохиромжгүй	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжтой	Нэн тохиромжтой	Дүн
Улсын дүн	6.3	37.0	19638.4	303998.2	332194.5	1237423
Баруун бүс	2.6	799.9	62846.7	63010.3	16175.2	142834.7
Завхан	1.8	504.5	31764.1	36685.2	8353.8	77309.4
Говь-Алтай	0.0	0.0	0.4	0.2	0.0	0.6
Баян-Өлгий	0.8	0.6	593.0	366.5	0.2	961.1
Ховд	0.0	291.3	3624.8	3616.3	2139.0	9671.4
Увс	0.0	3.5	26864.4	22342.1	5682.3	54892.2
Хангайн бүс	3.7	105.3	5471.7	69277.5	143193.7	218051.9
Орхон	0.0	0.0	0.0	440.0	5220.2	5660.2
Өвөрхангай	0.5	8.2	736.6	7107.6	28644.9	36497.9
Булган	0.0	0.0	2502.4	43116.7	69097.4	114716.5
Баянхонгор	3.2	97.1	1185.7	307.6	273.0	1866.7
Архангай	0.0	0.0	335.3	5931.9	8909.6	15176.8
Хөвсгөл	0.0	0.0	711.6	12373.7	31048.6	44133.8
Төвийн бүс	0.0	37.0	19638.4	303998.2	332194.5	655868.1
Төв	0.0	37.0	16303.4	179788.0	109741.5	305869.9
Сэлэнгэ	0.0	0.0	3329.2	107084.5	205307.3	315721.0
Дорноговь	0.0	0.0	2.2	0.0	0.0	2.2
Дархан-Уул	0.0	0.0	3.6	17125.7	17145.7	34275.0
Говь-Сүмбэр	-	-	-	-	-	-
Дундговь	-	-	-	-	-	-
Өмнөговь	-	-	-	-	-	-
Зүүн бүс	0.0	3.0	7217.3	69172.1	139121.1	215513.6
Дорнод	0.0	0.0	1617.2	38344.3	50620.8	90582.4
Сүхбаатар	0.0	3.0	5439.6	23373.9	1336.6	30153.1
Хэнтий	0.0	0.0	160.5	7453.9	87163.7	94778.0
Улаанбаатар	0.0	0.0	59.9	2524.3	2571.3	5155.6




Ургамлын болон бусад суурин аж ахуйн ГЗБ, хот суурины төлөвлөлт, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, ГЗБ-ын нарийвчилсан хайгуул судалгаа, шинжилгээ хийх нийт газрын хэмжээ*


Бүс, аймгийн нэр	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжтой	Нэн тохиромжтой	Тариаланд тохиромжтой нийт талбай, га
Улсын дүн	20160702.2	30743027.3	11180709.1	62084438.5
Баруун бүс	3629484.8	3150983.2	423092.7	7203560.6
Завхан	616743.9	1204355.6	39911.3	1861010.8
Говь-Алтай	1670011.5	321619.8	62198.8	2053830.1
Баян-Өлгий	389916.1	349666.4	17445.9	757028.4
Ховд	735494.2	389227.3	94934.5	1219656.0
Увс	217319.1	886114.1	208602.2	1312035.4
Хангайн бүс	6706361.4	8684759.5	2301189.0	17692309.9
Орхон	277.5	52331.1	25981.6	78590.2
Өвөрхангай	358990.5	1070580.0	381988.5	1811559.0
Булган	1508282.1	2502381.2	726782.9	4737446.3
Баянхонгор	1483535.6	597731.8	62129.2	2143396.6
Архангай	1249485.7	2092719.0	801218.9	4143423.6
Хөвсгөл	2105790.0	2369016.4	303087.8	4777894.3
Төвийн бүс	4400552.8	5911401.3	1770069.9	12082024.0
Төв	1513850.8	3082893.1	818265.1	5415008.9
Сэлэнгэ	984588.7	2058286.5	789955.6	3832830.7
Дорноговь	297345.8	192304.2	8283.7	497933.7
Дархан-Уул	34044.0	169104.4	79719.9	282868.2
Говь-Сүмбэр	5730.8	154491.1	42405.2	202627.1
Дундговь	338929.6	252062.1	31440.5	622432.2
Өмнөговь	1226063.2	2260.0	0.0	1228323.2
Зүүн бүс	5343536.7	12680396.1	6615220.0	24639152.8
Дорнод	2461841.1	5743410.2	4221615.0	12426866.3
Сүхбаатар	1537666.5	3303104.1	105061.0	4945831.7
Хэнтий	1344029.0	3633881.8	2288544.0	7266454.8
Улаанбаатар	80766.5	315487.2	71137.4	467391.1

*Тайлбар: Газар ашиглалтын аливаа зориулалт, төрлийг үл харгалзан тооцсон.

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ



Тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн төлөвлөсөн газар тариалан, суурин аж ахуйн бүсчлэл



Суурин ХАА-н газрын ГЗБ-н ажлын процесс

ГЗБ-ын мэргэжлийн байгууллагын хээрийн судалгааны экспедици ажиллуулж судалгаа хийх, ГЗБ-ын ажлын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх

Газар тариалан болон бусад суурин аж ахуй, уламжлалт нүүдлийн мал аж ахуй хоорондын хил зааг тогтоох газар зохион байгуулалтын цогц арга хэмжээг* хэрэгжүүлэх

Нутгийн иргэдэд болон хэт төвлөрлийг сааруулын тулд УБ хотоос хөдөө орон нутаг руу шилжин суурьших иргэдэд жижиг фермер, хоршоо, нөхөрлөл байгуулан өрхийн аж ахуй газар тариалан, мал, гахай, шувуу, зөгийн зэрэг аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн газрын шинэтгэлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн газар тариалан, суурин аж ахуй хөгжүүлэх бүс газрын суурь нөхцөлийн ерөнхий үнэлгээ*

Аймгийн нэр	Тариалангийн газрын тохиромжтой байдлаар суурин аж ахуй болон газар тариалангийн бүсийн талбай, га	Суурь нөхцөл, газар ашиглалтын байдал							
		Гидрогеологийн нөхцөл, га			Тариалангийн талбайн нөөц		Бусад газар ашиглалтын төрлүүд		
		Сайн	Хязгаар-лагдмал	Муу	Одоо байгаа тариалангийн газрын нөөц, га	Тариаланд тохиромжтой нөөц газар, га	Өвөлжөө хавар-жааны тоо	Ашигт малтмал ашиглалтын лиценз талбай, га	Ашигт малтмал хайгуулын лицензийн талбай, га
Улсын дүн	9446560.8	2500294.2	3864664.7	3082114.5	1440857.9	8005702.8	11360	73161.5	457520.2
Баруун бүс	623083.4	315960.0	215397.6	91736.2	148705.6	474377.9	1461	172.0	23401.0
Завхан	226857.7	52835.8	113431.1	60601.1	77330.4	149527.2	501		13490.0
Говь-Алтай	17968.4	7035.0	8235.4	2698.0	3369.6	14598.8	30	88.7	127.2
Баян-Өлгий	10450.2	7370.3	895.6	2184.3	961.1	9489.1	49		
Ховд	142151.1	112595.8	13502.3	16053.0	11842.5	130308.6	512	5.2	5558.6
Увс	225656.1	136123.0	79333.1	10199.9	55201.9	170454.1	369	78.0	4225.1



Хангайн бүс	2027230.5	784155.4	631023.9	612366.0	300685.5	1726545.0	3801	11603.1	43916.7
Орхон	27463.9	7377.3	8922.9	11163.8	6499.7	20964.2	83	43.1	236.9
Өвөрхангай	357326.6	116258.4	90897.8	150170.3	40329.1	316997.5	481		1391.9
Булган	770710.6	273249.9	198183.0	299283.0	133910.7	636799.9	1058	6905.7	38531.1
Баянхонгор	75140.0	21751.1	32932.9	20456.1	2460.3	72679.8	62		936.5
Архангай	546016.4	265664.1	195673.7	84988.2	72852.2	473164.2	1230	2673.0	1945.8
Хөвсгөл	250572.9	99854.6	104413.7	46304.7	44633.5	205939.4	887	1981.2	874.5
Төвийн бүс	3147965.4	787221.4	1185313.5	1175579.9	752049.4	2395916.0	4151	37176.0	105119.5
Төв	1418988.4	371353.2	508183.8	539598.8	378288.9	1040699.5	1236	20405.3	51044.0
Сэлэнгэ	1513025.4	368794.6	567648.1	576584.8	337164.9	1175860.5	2455	14756.0	47319.1
Дорноговь	3158.8	1862.8	683.0	613.0	505.5	2653.3	1		61.8
Дархан-Уул	133720.5	36334.1	53785.0	43601.5	35722.5	97998.0	350	1466.9	6588.3
Говь-Сүмбэр	45814.0	2883.5	39733.4	3197.0	166.9	45647.0	21	340.3	
Дундговь	29308.5	5547.6	12594.7	11166.2	55.1	29253.3	47		
Өмнөговь	3949.9	445.6	2685.7	818.7	145.5	3804.5	41	207.5	106.2
Зүүн бүс	3588047.6	591729.4	1813722.4	1182632.0	233364.6	3354683.0	1889	19964.6	283644.2
Дорнод	2123569.4	285907.1	1170882.9	666812.0	99611.1	2023958.3	1185	5182.2	178466.6
Сүхбаатар	92477.3	4119.1	50962.0	37396.2	31929.4	60547.9	50	39.9	4296.2
Хэнтий	1372000.8	301703.2	591877.6	478423.7	101824.1	1270176.7	654	14742.5	100881.4
Нийслэл	60233.8	21227.9	19207.3	19800.3	6052.9	54180.9	58	4245.8	1438.8
Улаанбаатар	51083.9	19559.8	19134.3	12391.5	5544.0	45539.9	56	4213.6	325.9
Багахангай	185.1		67.1	7229.6	13.5	171.5			
Багануур	8964.8	1668.1	5.9	179.2	495.4	8469.5	2	32.2	1112.9

*/*Тайлбар: Суурин аж ахуй хөгжүүлэх хайгуул судалгаа хийх, ГЗБ-ын зураг төсөл боловсруулахад тохиромжтой газар/*

Суурин ХАА-н газрын ГЗБЕТ-нд үндэслэн дараа шатны ГЗБГЗЗГ-аас хэрэгжүүлэх ГЗБ-ын ажлын чиглэл.

1. "Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 7.1.1-д "хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхэлсэн хүрээ, салбарын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангах" гэж заасны дагуу тариалангийн газрын ГЗБЕТ-г хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, график боловсруулж Засгийн газраар батлуулах.
2. Газар тариалан, суурин ХАА хөгжүүлэх ГЗБЕТ-нд тусгагдсан тариаланд тохиромжтой, газар тариалан болон суурин аж ахуй хөгжүүлэх газрыг Газрын тухай хуулийн 16.1.13-т "үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар;" гэж заасны дагуу Улсын тусгай хэрэгцээний газарт авах ажлыг хэрэгжүүлэх.
3. ГЗБЕТ-өөр тогтоосон тариаланд тохиромжтой газрын схем, Газрын тухай хуулийн 23.2.8-д "улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх", 23.2.15-д "газар зохион байгуулалт, газрын кадастрын судалгаа, шинжилгээний ажил эрхлэх" гэж заасны дагуу ГЗБ-ын мэргэжлийн байгууллагын хээрийн судалгааны экспидеци ажиллуулж ГЗБ-ын ажлын зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх.
4. Газрын тухай хуулийн 23.2.14-т "улсын хэмжээнд газрын кадастрын бодлогыг хэрэгжүүлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх" гэж заасны дагуу дээр дурдсан ГЗБ-ын ажлын/нарийвчилсан/ зураг төсөл, ТЭЗҮ-г газарт буулгаж зааглалт хийх, газрын кадастр, мэдээллийн сангийн ажлыг удирдан зохион байгуулах.
5. Дээр дурдсан заалтуудыг хэрэгжүүлэхдээ газар тариалангийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт зэрэг асуудлыг хамтарч шийдвэрлэх.



- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв, түүний салбарыг барих загвар төслүүдийг хэрэгжүүлэх, технологийн парк /Агропарк/ барих

Төлөвлөж буй ХАА-н хөгжлийн үндэсний цогцолбор

ХАА-н хөгжлийн үндэсний цогцолборыг байгуулж шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийг цогцоор нь шийдсэн ХАА-н нутаг дэвсгэрийн кластерыг бий болгохоор төлөвлөлт хийгдсэн. Хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний цогцолборыг Дархан-Уул аймагт байгуулахаар 220га газрыг төлөвлөсөн.



Төлөвлөж буй ХАА-н хөгжлийн үндэсний цогцолборын үйл ажиллагааны үндсэн чиглэл

1. ХАА-н шинжлэх ухааны техник технологийн хангамж, үйлчилгээний төв
2. ХАА-н төв бирж, үзэсгэлэн худалдаа*
3. ХАА-н ложистик терминалын үйлчилгээ
4. ХАА-н агуулахын аж ахуй*, худалдаа, маркетингийн төв

ХАА-н хөгжлийн үндэсний цогцолбортой кластер үүсгэн ажиллах байгууллагууд

1. Дарханы ХААИС *
2. Дарханы ургамал ГТ-н хүрээлэн
3. Дарханы МАА-н хүрээлэн*
4. Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн*
5. Ургамал хамгаалалын эрдэм шинжилгээний хүрээлэн*
6. ХАА-н ургамал хорио цээрийн алба
7. ХАА-н агро паркүүд*
8. ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүд
9. ХАА-н ААН, фермерүүд

Тайлбар: * Улаанбаатар хотоос Дархан-Уул аймагт шилжүүлэн байршуулах байгууллагууд



ХАА-н агропарк байгуулах газрын ГЗБЕТ, схем

ХАА-н агропарк нь үйлдвэр, фермерүүд, нөхөрлөл, хоршоод, аж ахуйнуудыг дэмжсэн тогтвортой ногоон хөгжлийн загвар схемийн дагуу кластерыг бий болгоход чиглэгдэнэ. Улсын хэмжээнд эхний ээлжид тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурлан 25 байршилд Агро паркийг байгуулахаар төлөвлөсөн байна. Агро паркийн цогцолбор байгуулах газрын хэмжээ 2100 га. Одоо байгаа аж ахуй, объект, материаллаг бааз, нутгийн иргэдийн уламжлалт мэдлэг, туршлагын нөөц чадавх, дэд бүтцийн хангамж, тариалангийн газрын нөөц, усны нөөцийн боломжийг харгалзан байршлыг сонгосон. Үүнд:

- **Мах-Сүү, Сүү-Махны агро парк-11:** Орхон аймгийн Жаргалант, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Дархан-Уул аймгийн Хонгор, Булган аймгийн Орхон, Завхан аймгийн Асгат, Хэнтий аймгийн Хэрлэн, Дорнод аймгийн

- Баянтүмэн, Чулуунхороот, Халхгол сумууд, Төв аймгийн Батсүмбэр;
- **Гахайн агро парк-1:** Сэлэнгэ аймгийн Мандал;
 - **Шувууны агро парк-1:** Ховд аймгийн Жаргалант;
 - **Үр үржүүлгийн агро парк-1:** Дархан-Уул аймгийн Хонгор;
 - **Тэжээлийн агро парк-4:** Завхан аймгийн Баянтэс, Хөвсгөл аймгийн Мөрөн, Хэнтий аймгийн Хэрлэн, Сэлэнгэ аймгийн Баянгол;
 - **Хүнсний ногооны агро парк-1:** Дархан-Уул аймгийн Орхон сум;
 - **Жимс жимсгэний агро парк-4:** Өвөрхангай аймгийн Хархорин, Увс аймгийн Улаангом, Ховд аймгийн Булган, Сэлэнгэ аймгийн Шаамар;
 - **Хүлэмжийн агро парк-2:** Өмнөговь аймгийн Цогтцэций, Нийслэлийн Багануур дүүрэг /шинээр байгуулахаар төлөвлөсөн ДЦС-д тулгуурлан хөгжинө/.



ХАА-н агропарк байгуулах байршлын үзүүлэлт

Агропарк байгуулах газрын байршлыг сонгосон хэрэгцээт болон тохиромжтой байдал, нөөц, төлөвлөлтийн үзүүлэлт		Ач холбогдол				
Тариалангийн газрын нөөц, га	Усны нөөцийн боломж	Дэд бүтцийн хангамж	Одоо байгаа аж ахуй, объект, материаллаг бааз	Уламжлалт мэдлэг, туршлагын нөөц чадавч	Хэрэгцээ, гүйцэтгэх үндсэн үүрэг	Ач холбогдол
Нийт тариалангийн талбай 31.6 мянган га үүнээс уринш 15.5 мян.га, өнжөөсөн 5.2 мян.га	Хараа гол, Шарын гол зэрэг голуудтай. Газрын доорх усны локал, хязгаарлагдмал нөөц бүхий устай	Олон улсын чанартай хатуу хүчилтэй авто зам, төмөр замтай бөгөөд төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон 110квт-н агаарын шугамтай	Дарханы УТГЭШ Хүрээлэн	Соц нийгмийн үед Хонгор сум урийн аж ахуйн чиглэлээр төрөлжин хөгжиж байсан	Улсын хэмжээнд ургамлын аж ахуйн үр үржүүлэг, нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх,	Улсын хэмжээнд ургамлын аж ахуйн үрийн хэрэгцээг дотооддоо хангах, импортыг орлох
Нийт тариалангийн талбай 17.5 мянган га үүнээс уринш 6.0 мян.га, өнжөөсөн 4.0 мян.га, атаршсан 133га	Сумын төв орчмоор Хараа гол, хойд хэсгээр Баянгол зэрэг гадаргын устай, газрын доорх усны ундарга ихтэй их тархалттай	Олон улсын чанартай хатуу хүчилтэй авто зам, төмөр замтай бөгөөд төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон 110квт-н агаарын шугамтай	Тэжээлийн үйлдвэр ажиллаж байгаа.	Үйлдвэрийн техникийн болон хүний нөөцтэй.	1.Улсын хэмжээнд шувууны тэжээлээр хангах. 2.Төвийн бүсийн эрчимжсэн АА-г хангах	Шувууны аж ахуйн тэжээлийн үндэсний үйлдвэртэй болж хангамжийн хараат байдлыг арилгах, ажлын байрыг нэмэгдүүлэх
Нийт тариалангийн талбай 28.3 мянган га үүнээс уринш 6.7 мян.га, өнжөөсөн 9.7 мян.га, 5.3 мян.га тэжээлийн ургамал тариалсан талбайтай	Сумын төвийн урддур Хэрлэн гол урсах ба газрын доорх усны тархалт, ундарга ихтэй устай давхарга /Нүх сувийн устай/ бүсэд байршина	Улсын чанартай хатуу хүчилтэй авто замтай, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон 110квт-н агаарын шугамтай	Тэжээлийн үйлдвэр ажиллаж байгаа.	Үйлдвэрийн техникийн болон хүний нөөцтэй.	Зүүн бүсийн эрчимжсэн АА-г хангах	Хэнтий, Сүхбаатар мал, амьтны аж ахуйг тэжээлээр хангах
Тариалан, Эрдэнэбулган, Рашаант, Их-Уул сүмдаас түүхий эдээ авах бөгөөд эдгээр сүмдын тариалангийн эргэлтийн нийт талбай 17.3 мян.га	Сумын төвийн урддур Дэлгэрмөрөн урсдаг ба газрын доорх усны тархалт, ундарга ихтэй устай давхарга /Нүх сувийн устай/ -н бүсэд оршино	Улсын чанартай хатуу хүчилтэй авто замтай, эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон 35квт-н агаарын шугамтай	Тэжээлийн үйлдвэр ажиллаж байгаа.	Үйлдвэрийн техникийн болон хүний нөөцтэй.	Хангайн бүсийн эрчимжсэн АА-г хангах	Хэнтий, Сүхбаатар мал, амьтны аж ахуйг тэжээлээр хангах
Улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн газар болон тусгай зөвшөөрөлтэй ангийн бүстэй /ховор ангийн/ ашигт малтмал хайгуулын болон ашиглалтын зарим тусгай

зөвшөөрөл бүхий газрууд давхардаж байгааг цаашид судалгаа хийж, нөхөн олговрын хэмжээг тооцсоны үндсэн дээр зохицуулалт хийх, шийдвэр гаргахаар төлөвлөв.

Бусад салбарын төлөвлөлттэй давхардсан судалгаа, зохицуулалт хийх шаардлагатай АМ хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газар



Төлөвлөсөн тусгай хамгаалалттай газар нутагт ашиглалтын 51 лицензийн 106266.2га, хайгуулын 112 лицензийн 527740.3га, тусгай зөвшөөрөл бүхий ангийн бүс нутагт 29 лицензийн 14846га, хайгуулын 76 лицензийн 369208.7 га газар тус тус давхцаж байна. /АМГТХЭГ-с 2018 оны 09 сарын 10-ний өдөр ирүүлсэн тоон зурагт үндэслэн тооцсон/

3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил

Геологийн зураглал болон ерөнхий эрлийн ажлыг 1:200000 масштабтайгаар нийт нутаг дэвсгэрийн 99%-д хийсэн бөгөөд 1:50000 масштабтай зураглал, ерөнхий эрлийн ажлыг 33,7%-д хийсэн байна. /АМГТГ-н 2016 оны үйл ажиллагааны тайлан/

Цаашид улсын төсвийн хөрөнгөөр 1:50000 масштаб бүхий геологийн зургийг 2020он хүртэлх хугацаанд 22137 мянган га газарт гүйцэтгэхээр “Уул уурхай хүнд үйлдвэрийн яам” төлөвлөсөн бөгөөд 2018 онд 12711 мянган га газарт хийж дуусахаар байна. /УУХҮЯ-с/

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх 1:50000 масштаб бүхий геологийн зураглал хийх талбай

1:50000 масштабтай геологийн зураглал хийж буй болон хийхээр төлөвлөсөн	Талбай /га/	Үүнээс: Тусгай хамгаалалттай газарт				
		УТХГ-д	Үүнээс: УТХГ-н төрлөөр			
			ДЦГ	БНГ	БЦГ	ДГ
Хийгдэж байгаа	12711633	1699751	1193146	69624	425832	11149
2019 онд хийхээр төлөвлөсөн	5132416	1622089	468616	498162	655311	
2020 онд хийхээр төлөвлөсөн	4293118	2610692	1887522	487247	235923	
Дүн	22137167	5932532	3549284	1055033	1317066	11149

4. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох газар

УУХҮЯ-с авсан мэдээллээр Засгийн газрын 2014 оны 239, 2015 оны 511, 2017 оны 37, 234 дүгээр тогтоолуудаар батлагдсан сонгон шалгаруулалтын талбайгаас хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой 8,6 сая гектар талбайг ялган багцалж аймаг, нийслэлээс санал авахаар хүргүүлсэн бөгөөд эцсийн байдлаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбай 8.48 сая га болгон МУ-н засгийн газраар батлуулсан байна.

Цаашид бусад салбарын төлөвлөлтийн хүрээнд уг талбайтай давхардсан газруудад нэн тэргүүнд хайгуул судалгаа, ерөнхий эрлийн ажил хийсний үндсэн дээр шийдвэр гаргах, зохицуулалт хийх арга хэмжээг төлөвлөж байна.

Бусад салбарын төлөвлөлттэй уялдуулан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайгаас эхний ээлжид хайгуул судалгаа, ерөнхий эрлийн ажил хийж шийдвэр гаргах, зохицуулалт хийх газар

№	Аймгийн нэр	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайтай давхацсан төлөвлөлтүүд					Давхцалтай нийт талбай / га/
		Хот суурины эдэлбэр газрыг тэлэх	Төлөвлөсөн суурин ХАА-н бүс	Төлөвлөсөн ТХГН	Хамгаалалтад авах гүний усны тэжээгдлийн мүүж	Тусгай зөвшөөрөлтэй ангийн бүс	
1	Архангай		9206.26	110.38			9316.64
2	Баян-Өлгий	660.65	365.25	45836.27	3.49	55363.08	102228.75
3	Баянхонгор		206.58	26151.39		345.83	26703.81
4	Булган	157.68	62695.01			16.33	62869.01
5	Говь-Алтай		569.70	150645.17	11.35	141541.31	292767.54
6	Говьсүмбэр		358.24		1075.52	3948.15	5381.91
7	Дархан-Уул	580.46	14885.61				15466.07
8	Дорноговь	18.65		72978.01	465.60	18395.02	91857.28
9	Дорнод		130416.94	31650.11	612.56		162679.62
10	Дундговь	228.38	41.40	211.39	2.69	7239.89	7723.76
11	Завхан	12.65	8172.94	3723.36		6419.33	18328.28
12	Орхон						0.00
13	Өвөрхангай	547.16	12758.75	21105.73			34411.64
14	Өмнөговь	822.33	197.90	39746.59	952.69		41719.52
15	Сүхбаатар	93.29	4638.29	514.03	821.26	8410.09	14476.96
16	Сэлэнгэ	917.30	109989.82		6.25		110913.37
17	Төв	709.97	98424.35	4048.61	11.79	39822.02	143016.74
18	Увс	228.54	1036.56	1150.54			2415.64
19	Ховд	12.64	2506.08	38608.27	54.28	6673.31	47854.59
20	Хөвсгөл	667.40	12015.66	7.62	116.36		12807.05
21	Хэнтий		67915.03	138.21		1124.87	69178.11
22	Улаанбаатар	6716.10	3061.58				9777.69
	Дүн	12373.22	539461.96	436625.70	4133.84	289299.24	1281893.95




ЧӨЛӨӨТ БҮС, ХИЛИЙН БООМТ

Монгол Улс гадаад худалдаа, хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхийн тулд Цагааннуур, Хандгайт, Арц суурь, Булган, Бургастайн чиглэлээр ОХУ, БНХАУ-ын худалдаа-эдийн засгийн сүлжээнд холбох зорилтыг үе шаттай хэрэгжүүлэх, цаашид Таванбогдын шилийн чиглэлээр улсын хөндлөн гол тэнхлэгийг /мянганы зам/ Дундад Ази Ойрх Дорнодын орнуудтай холбох боломжийг судлах түүнчлэн эхний ээлжид ОХУ-тай хил залгаа “Алтанбулаг” /Сэлэнгэ аймаг/ “Цагааннуур” /Баян-Өлгий аймаг/ БНХАУ-тай хил залгаа “Замын-Үүд” /Дорноговь аймаг/ боомтод түшиглэн худалдаа, гаалийн тусгай /чөлөөт/ бүсүүд байгуулж, олон улсын жишгийн дагуу уг бүсүүдийн хүрээнд дотоод, гадаадын худалдаа эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад харилцан ашигтай, хамтран ажиллах, бизнесийн орчныг бүрдүүлэх, зохих туршлага бүрдмэгц Монгол Улсын нутаг дэвсгэрийн гүнд тусгай /чөлөөт/ бүсийг зохистой төрөл чиглэлээр байгуулах ажлыг өргөжүүлэх зорилт тавьсан байна.

УИХ-ын 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн чуулганаар Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар өмнө нь мөрдөж байсан Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хууль, “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг хүчингүй болгосон байна. Чөлөөт бүсийн тухай хуульд орсон энэ өөрчлөлтөөр бүх чөлөөт бүс ижил статустай бөгөөд өөрийн чиг үүргээрээ ажиллах болжээ.

“Алтанбулаг”-т 500га, “Замын-Үүд”-900 га, “Цагааннуур”-т 708.4 га, бүх чөлөөт бүсүүдэд нийт 2108.4 га газар эзэмшүүлсэн байна. Одоогоор Алтанбулаг чөлөөт бүсээс бусад чөлөөт бүсүүд албан ёсоор байнгын үйл ажиллагаа эхлээгүй байна.

Монгол Улсын өнөөгийн чөлөөт бүсүүдийн байршил



ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Чөлөөт бүсэд машин үйлдвэрлэл, металл, арьс шир боловсруулалт зэрэг өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт дэвшилтэт техник, технологи /ноу-хау/ нэвтрүүлэх, нутагшуулах, инноваци, мэдлэг шингэсэн үйлдвэрлэлийг кластераар чөлөөт бүсийн гаднах үйдвэрүүдтэй цогцоор хөгжүүлэх ГЗБ-н төлөвлөлтийн төслүүдийг төлөвлөв.



Чөлөөт бүсийн хөгжлийн чиг хандлага, чөлөөт бүсийн ГЗБ-ын хэрэгжих төсөл, арга хэмжээ

№	Хуулийн заалт болон хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, үр дүн	Хэрэгжих төсөл, арга хэмжээ	Хэрэгжих төсөл, арга хэмжээний ерөнхий үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих жил	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт
1	“Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.17-2.19 заалт.	Байгуулагдсан чөлөөт бүсүүдийн бүтээн байгуулалтыг төслүүдийг дуусгаж үйл ажиллагааг жигдрүүлэх арга хэмжээнүүд	дэд бүтцийн төслүүд	1.Төр газрын өмчлөгчийн эрхээр зохицуулна. 2.Засгийн газар, Чөлөөт бүсийн ажлын албад	2018-2020	Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилт, чөлөөт бүсэд газар эзэмшигч, ашиглагчийн оруулсан хөрөнгө, бараа эргэлтийн дүн
2	“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ийн 3.2.1.7-3.2.1.9, 3.2.2.4-3.2.2.5, “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ийн 2, 3 заалт, “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ийн 4.2.5.4-4.2.5.5, “Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний стратеги-4.1, “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.5, 3.5.1 заалт.	Умард Ирландын вант Улсын Шэннон онгоцны буудалд чөлөөт бүс байгуулсан туршлагыг судалж Хөшигийн хөндийн нисэх буудалд хөнгөн үйлдвэрийн чөлөөт бүс байгуулж дэлхийд нэр хүнд бүхий гадаадын/Итали, Герман зэрэг орны/ үйлдвэрт ноу-хау нөхцөлөөр технологи, хөрөнгө оруулах онцгой боломж олгох хэлэлцээрийг байгуулах төсөл. Эрдэнэт, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг чиг үүргийн хандлагаар аж үйлдвэрийн өндөр технологийн чөлөөт бүс болгож дэлхийд нэр хүнд бүхий гадаадын/Япон, Герман зэрэг орны / үйлдвэрт ноу-хау нөхцөлөөр технологи, хөрөнгө оруулах онцгой боломж олгох хэлэлцээрийг байгуулах төсөл.	1.Хагас боловсруулсан арьс ширийг гүн боловсруулж бэлэн хувцасны оёдлын үйлдвэр-1-2, 2.Гуллын үйлдвэр-1, 3.Оёдлын үйлдвэр -3 төрлөөр.	1.Төр газрын өмчлөгчийн эрхээр зохицуулна. 2.Засгийн газар, ГЗБГЗЗГ, Үндэсний хөгжлийн газар, Чөлөөт бүсийн ажлын алба 1.Төр газрын өмчлөгчийн эрхээр зохицуулна 2.Засгийн газар, ГЗБГЗЗГ, Үндэсний хөгжлийн газар, Чөлөөт бүсийн ажлын алба	2018-2024	Засгийн газартай байгуулсан шууд хөрөнгө оруулалтын гэрээ, нэвтрүүлэх ноу-хау технологийн нэр

<p>Газрын тухай хуулийн 19.1.1.газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах; 23.2.1. газрын талаар Засгийн газраас баримтлах бодлогыг хэрэгжүүлэх; 23.2.4. улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх;</p>	<p>Чөлөөт бүсийн газрын харилцааны хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох хуулийн төсөл</p> <p>Чөлөөт бүсийн газрын эрхийн харилцаа, зохицуулалт, чөлөөт бүсийн газрыг үнэ хүргэх зорилгоор биш, үйлдвэр, спортыг дэмжих зорилгыг дэмжсэн ГЗБ-ын журам, заавар</p> <p>3.Газрыг эд хөрөнгийн хэлбэрт шилжүүлж Иргэний хуулийн дагуу түрээслэх журам</p>	<p>2018-2020</p>	<p>Батлагдсан хууль, журам, зааврын тоо</p>
<p>Чөлөөт бүсийн тухай хуулийн 7.1.3.чөлөөт бүсийн үйл ажиллагааг үйлдүүлэн зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах;</p>	<p>Монголын талаас хөнгөн, хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн, эко төмс, хүнсний ногоо, гадаад орнуудаас жижиг, дунд үйлдвэрийн шугам, тоног төхөөрөмжийн олон улсын үзэсгэлэн худалдааг Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур бүсүүдэд зохион байгуулах арга хэмжээ</p>	<p>2018-2020</p>	<p>Чөлөөт бүсээр дамжин борлуулагдсан үйлдвэрийн шугам, тоног төхөөрөмжийн тоо, үнийн дүн</p>
<p>1.Газрын тухай хуулийн 23.2.4. улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх; 2.Чөлөөт бүсийн тухай хуулийн 22.4.Газар эзэмших, ашиглах эрхийг төсөл сонгон шалгаруулах, дүүдлага худалдааны аль нэг хэлбэрийг ашиглан олгоно.</p>	<p>Эхний ээлжинд чөлөөт бүсүүдэд жижиг, дунд үйлдвэрийн шугам, тоног төхөөрөмж нийлүүлэх гадаадын үйлдвэрүүдэд газар түрээслүүлэх ГЗБ-ын арга хэмжээ</p>	<p>2018-2020</p>	<p>Батлагдан мөрдөж буй журам, зааврын тоо</p>
<p>5.1.5.чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж, байгууллага итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин, нөхцөл бий болгох;</p>	<p>Чөлөөт бүсийн онцлогт нийцүүлэн уг бүсэд төр газар өмчлөгчийн хувьд зохицуулах эрх мэдэл, газар, эзэмшүүлэх, ашиглуулах эрх үүсгэх, эрхийг цуцлах, дүүсгавар болгох, тэдгээрт тавигдах шаардлага, төрөөс газрын эрх бүхий этгээдтэй байгуулах ГЗБ-ын журам, заавар гэрээний нөхцөл, болзол, газар хамгаалал</p>	<p>2018-2020</p>	<p>Батлагдан мөрдөж буй журам, зааврын тоо</p>



21.3.Хөрөнгө оруулагч нь чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр чөлөөт бүсийн менежментийг хэрэгжүүлж болно	Чөлөөт бүсийн төрийн болон бизнесийн удирдлагын зааг ялгааг тогтоох, төрийн үйлчилгээг ТББ-аар гүйцэтгүүлэх журам, заавар боловсруулах арга хэмжээ	Чөлөөт бүсийн менежментийг бизнесийн ТББ-аар удирдуулах журам, заавар, гэрээ	Шадар сайд, Чөлөөт бүсийн ажлын алба	2018-2020	Боловсруулсан баримт бичгийн тоо
“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ийн 3.2.2.4 заалт	Чөлөөт бүсийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны нэвтрүүлэлтийн үр ашгийн шалгуур үзүүлэлт тогтоох арга зүйг боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөл	Зөвлөх үйлчилгээний баримт бичгүүд, 30.0 сая төг.	Шадар сайд, Чөлөөт бүсийн ажлын алба	2018-2020	Батлагдсан арга зүйн заавар
Чөлөөт бүсийн тухай хуулийн 20.3.Чөлөөт бүс, аймаг, орон нутгийн нийтлэг ач холбогдолтой үйлдвэрлэлийн дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй байхаар хөгжүүлэх төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.	Чөлөөт бүсүүдийн хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөнд орон сууц, суурьшлыг чөлөөт бүсийн гадна гэр хорооллыг дахин төлөвлөж дэд бүтцийг орон нутгийн нийтлэг хэрэгцээг хангах тодотголын төсөл хэрэгжүүлэх	Чөлөөт бүсүүдийн хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөний тодотгол 30.0 сая төг	ГЗБГЗЗГ, Чөлөөт бүсийн ажлын алба	2018-2020	Алтанбулаг, Замын үүдийн чөлөөт бүсийн Ерөнхий төлөвлөгөөний тодотголын 2 баримт бичиг.

Хилийн боомтуудын дэд бүтэц зам харилцааны байдал, сайжруулах арга хэмжээний төлөвлөлт*

№	Байршил аймаг, сум, боомтын нэр	Дэд бүтэц зам харилцаа	Боомтуудын төлөвлөлт			Дэд бүтэц зам харилцааг сайжруулах төлөвлөлт
			Сайжруулан өргөтгөх	Хаах	Шинээр нээх	
1	Сүхбаатар Эрдэнэцагаан Бичигт	Тамсаг-бичигт чиглэлийн хатуу хучилттай авто замтай	Олон улсын хилийн боомт болон өргөжүүлэн тохижуулж, байнгын ажиллагаатай болгох	-	-	*Хил худалдааг Дэмжих үйлчилгээний танхим байгуулах Хөөт –Бичигт чиглэлийн төмөр зам, Баруун-Урт-Бичигт чиглэлийн авто зам төлөвлөгдсөн
2	Дорнод Халхгол Рашаант	Шороон зам	-	Зүүн хойд Азийн бүс нутгийн ачаа тээвэр, худалдааны ба арилжааны чухал төв болгон тохижуулан хөгжүүлэх.	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Чойбалсан-Халхгол-Рашаант чиглэлийн авто болон төмөр зам 2020 оноос хойш барихаар төлөвлөгдсөн

3	Ховдын Булган Ярант	Хөшөөтийн хүүрсний уурхай болон Ховд хот руу хатуу хучилттай авто замаар холбогдсон	Олон улсын чанартай болгох	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Хөшөө-Ярант чиглэлийн төмөр зам төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогод тусгагдсан
4	Говь-Алтай Алтай Бургастай	Шороон зам	Улсын хилд ойртуулан шилжүүлж, хэлэлцээрийн дагуу ажиллуулах, тохижуулах	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Алтай хот-Бургастай чиглэлийн авто болон төмөр зам төлөвлөсөн
5	Өмнөговь Гурвантэс Шивээ хүрэн	Шороон зам	Улсын хилд ойртуулан шилжүүлж, байнгын ажиллагаатай болгох.	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Даланзадгад-Гурвантэс-Шивээ хүрэн чиглэлийн авто болон төмөр зам төлөвлөсөн
6	Өмнөговь Ханбогд Гашуун сухайт	Оюутолгой, таван толгойн нүүрсний ордоос боомт хүртэлх хатуу хучилттай авто замтай	-	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Таван толгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам төлөвлөгдсөн
7	Дорноговь Замын-Үүд Замын үүд	Авто болон төмөр замаар аймаг, нийслэлтэй холбогдсон,	Чөлөөт бүсийн төв болгон өргөтгөн хөгжүүлэх, Олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомт болгох	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Чөлөөт бус байгуулахаар төлөвлөгдсөн бөгөөд инженерийн цогц дэд бүтцийн байгууламж барих
8	Дорноговь Хатанбулаг Ханги	Шороон зам	-	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Сайншанд-Ханги чиглэлийн авто болон төмөр зам төлөвлөгдсөн
9	Ховд Булган Байтаг	Шороон зам	Булган-Такашкен боомтыг байнгын ажиллагаатай болгох тохиолдолд хаах.	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	-
10	Дорнод Чойбалсан Хавирга	Шороон зам	-	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Чойбалсан хот-Хавиргын боомт чиглэлд авто зам барихаар төлөвлөсөн




11	Дорнод Халх Баянхошуу	Шороон зам	-	Тухайн хэсэгт Нөмрөг- Рашаантын чиглэлд шинээр боомт нээх тохиолдолд хаах.	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Тамсагбулаг-Баянхошуу чиглэлд авто зам барихаар төлөвлөсөн, Чойбалсан-Халх гол чиглэлийн төлөвлөсөн замтай огтлолцоно
12	Ховд Булган Булган	Шороон зам	Олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомт болгох	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	-
13	Сэлэнгэ Сүхбаатар Сүхбаатар		-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	-
14	Сэлэнгэ Алтанбулаг Алтанбулаг	Авто болон төмөр замаар аймаг нийслэл хотуудтай холбогдсон	Олон улсын чөлөөт бүсийн төв болгон хөгжүүлэх	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Чөлөөт бүс байгуулахаар төлөвлөгдсөн бөгөөд инженерийн цогц дэд бүтцийн байгууламж барих
15	Дорнод Чулунхороот Эрэнцэв	Төмөр замаар аймгийн төвтэй холбогдсон,	Хэлэлцээрийн дагуу олон улсын зорчигч, ачаа тээврийн харилцааны боомт болгох.	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Чойбалсан-Эрэнцэв чиглэлийн авто зам төлөвлөгдсөн
16	Дорнод Баян-Уул Ульхан майхан	Шороон зам	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Чойбалсан-Ульхан, Хэнтий аймгийн Хэрлэн-Норовлин-Ульхан чиглэлийн авто зам төлөвлөгдсөн
17	Баян-Өлгий Цагааннуур Цагааннуур	Шороон зам	Хэлэлцээрийн дагуу олон улсын зорчигч, ачаа тээврийн боомт, чөлөөт бүсийн төв болгох.	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Өлгий-Цагааннуур чиглэлийн авто зам төлөвлөгдсөн, Чөлөөт бүс байгуулахаар төлөвлөгдсөн бөгөөд инженерийн цогц дэд бүтцийн байгууламж барих
18	Увс Давст Боршоо	Аймгийн төв рүү 58км хатуу хучилттай авто зам тавигдсан	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	-
19	Завхан Тэс Арцсуурь	Шороон зам	-	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Нөмрөг-Арцсуурь чиглэлийн авто зам, Могойн голын уурхай-Арцсуурь чиглэл болон Өндөрхангай-Арцсуурь чиглэлийн төмөр замууд төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогод тусгагдсан



20	Хөвсгөл Ханх Ханх	Шороон зам	Өргөжүүлэн тохижуулж, хэлэлцээрийн дагуу ажиллуулах	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Хатгал-Ханх чиглэлийн авто зам төлөвлөгдсөн
21	Булган Тэшиг Бага-Илэнх	Шороон зам	Хилийн боомт болгон тохижуулах	-	-	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Хутаг-Өндөр-Бага илэнхи чиглэлийн авто зам төлөвлөгдсөн
22	Баян-өлгий Улаан байшинт	Цагааннуур-Улаанбайшинт чиглэлт хатуу хүчилттай замтай, Шороон зам	-	-	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутаг, хилийн 31 дүгээр тэмдгийн чиглэлд шинээр байгуулах.	*Хил худалдааг дэмжих үйлчилгээний танхим байгуулах	Өлгий-Цагааннуур чиглэлийн авто зам төлөвлөгдсөн






Хархорин, Эрдэнэзуу цогцолбор /Өвөрхангай аймгийн Хархорин/

Таних тэмдэг

- Сумын төв
 - Аялал жуулчлалын нөөц бүхий газрууд
 - ◆ Халуун рашаан
 - ◆ Хүйтэн рашаан
 - ▲ Эмчилгээний элс
 - Эмчилгээний шаврын орд
 - Нуур
 - Улсын хил
 - Аймгийн хил
- Тусгай зөвшөөрөл бүхий ангийн бүс**
- Аргаль
 - Аргаль, Буга
 - Аргаль, Янгир
 - Янгир
 - Буга
 - Бор гөрөөс, Гахай, Шувуу

- Аялал рекреацийн ерөнхий бүс**
- Тэргүүлэх чиглэл нь экосистемийн үйлчилгээнд суурилсан аялал жуулчлалын бүс
 - Тэргүүлэх чиглэл нь олзворын ан, түүх соёлын нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын бүс нутаг

**УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018 - 2025 он/
 Аялал рекреацийн нөөц бүхий газрын УГЗБЕТ-ний схем зураг
 /шинээр төлөвлөж буй АЖ-н цогцолборууд/**



- Төлөвлөж буй АЖ-н томоохон цогцолбор**
- Түүх соёлын АЖ-н цогцолбор
 - Эко аялал жуулчлалын цогцолбор
 - Шашин мөргөл, Түүх соёл, Угсаатны зүйн АЖ-н цогцолбор
 - Эмчилгээ сувилал /тохижуулж, сайжруулах/
 - Палеонтологий судлалын цогцолбор
 - Чөлөөт бүс
 - Наран шарлага
 - Онгон байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх бүс

Тэргүүлэх чиглэл нь түүх соёл, тал хээрийн экосистемийн нөөцөд суурилсан аялал жуулчлалын бүс

АЖ-н цогцолбор байгуулахаар төлөвлөж буй газрын хил

3. Аялал рекреацийн нөөц бүхий газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ

Баруун бүсийн аялал жуулчлалын нөөцийн үнэлгээ:

1997 онд Дэлхийн шим мандлын нөөц газрын сүлжээнд хамрагдсан Увс нуурын ай савын Дархан цаазат газар, Баян-Өлгий, Ховд, Увс аймгийн Алтай Таван богд, Цамбагарав, Цэнгэл хайрхан, Мөнх хайрхан, Цагаан дэглий, Цагаан шувуут, Түргэний нуруу, Хархираа зэрэг өндөр уулс, Тэс Түргэн, Хархираа, Хангилцаг зэрэг түргэн урсгалт голууд байдаг. 1966 онд ЮНЕСКО-гоос Ховд хотын дэргэдэх Ямаат-Улаан гэдэг нүцгэн улаан буурал уул, Манхан сумын нутаг дахь Хойд Цэнхэрийн агуй, мөн дархан цаазат Отгонтэнгэр уулыг "Дэлхийн гайхамшигт үнэт зүйл болох нь" зэрэглэлээр дэлхийн соёлын өвд бүртгэж авсан байна.

Улаангом хотын дэргэдэх Чандмань Улаан уулын археологийн олдвор нь эртний түүх, соёлын нандин өвд зүй ёсоор тооцогддог.

Монгол орны үзэсгэлэнт байгаль, баруун Монголын олон ястны амьдрал ахуй зэргийг сонирхуулах өргөн боломжтой. Зэгс, хулсан шагшуурга дунд завиар аялан, ховор жигүүртэн шувууд болон усны амьтдыг үзэх, загасчлах чиглэлээр Увс нуур, мөн Хар-ус нуурын өмнөд эргээр аялал жуулчлалын бааз байгуулах нөөц байна. Ховд аймгийн Хар-ус нуурын хойд эргээр усан спорт хөгжүүлэх боломжтой. Баруун бүсэд түүх-археологийн болон шашин угсаатны чиглэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломж байна.

Хангайн бүсийн аялал жуулчлалын нөөцийн үнэлгээ

Цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэн бүхий Хөвсгөлийн бүсэд усан онгоц, завиар аялах, үзэсгэлэнт байгаль, ан амьтан, шувуу ажиглах, боломжтой газарт загасчлах, өвлийн улиралд цана, тэшүүр, уулын цанын спортыг хөгжүүлэх, дархад цаатан ардын амьдрал ахуй, зан заншил, соёл, цааны аж ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Монголын түүх, соёлын ховор нандин дурсгал, үзэсгэлэнт байгаль бүхий Орхон голын бүсэд эртний олон овог аймаг, улс гүрний үлдээсэн түүх, соёлын дурсгалт зүйл, хот, балгасны туурь, хөшөө, Монголын модон сийлбэрийн урлаг, Монголын ард түмний ахуйн соёл, зан үйлтэй танилцуулах, морь, сарлаг унуулах, загасчлах, рашаан эмчилгээ, сувилгаа хийлгэх, байгалийн элдэв сонин тогтоц, үзэсгэлэнт газрыг ажиглах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Төвийн бүсийн аялал жуулчлалын нөөцийн үнэлгээ

Эх газрын говийн байгаль, ан амьтан, дотоодын аялал жуулчлал, соёлын аялал жуулчлал, говийн бүсэд говийн унаган төрхөөрөө байгаа эмзэг онгон байгаль, ургамал, цаг уурын үзэгдэл, байгалийн элдэв сонин тогтоц, ховор ан амьтныг ажиглах, эртний шим ертөнцийн үлдэгдэл, палеонтологийн олдворыг үзүүлэх, зөвшөөрөгдсөн зарим ан амьтныг агнуулах, нар, элсний эмчилгээ засал, сувилгаа хийх, тэмээний аж ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Зүүн бүсийн аялал жуулчлалын нөөцийн үнэлгээ

Их эзэн Чингис хааны амьдрал ахуйтай холбоотой Гурван голын сав нутгийн бүсэд Чингис хааны нэртэй холбоотой газар нутаг, хөшөө дурсгалыг үзэж сонирхох боломжтой. Хэнтийн нурууны үзэсгэлэнт онгон байгаль, ан амьтан үзэх, Монголын эртний түүх, соёлын дурсгалт хөшөө, булш, бунхан үзэх, буриад зоны зан заншил, соёл ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Тал хээрийн онгон байгалийг харуулсан дорнод талын бүсэд уужим их тал хээрийн нутаг, ан амьтан, шувуу ажиглах, сөнөсөн галт уулсаар аялах, эртний хүн чулуун хөшөөнүүд үзэж сонирхох, дэлхийн II дайны түүхийг харуулсан цогцолбор дурсгалтай танилцуулах, зээр, гөрөөс агнах, дорнод Монголын ард түмний зан заншил, соёл, ахуйтай танилцах, байгалийн халуун уур агаарыг эмчилгээ, сувилгаанд ашиглах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.



Улаанбаатар бүсийн аялал жуулчлалын нөөцийн үнэлгээ

Монголын ард түмний эртний болон одоогийн хөгжил дэвшлийг харуулах, төрөл бүрийн музей үзэх, Нийслэл хотын байдалтай танилцах, хурал зөвлөгөөн, бизнесийн уулзалт зохион байгуулах, Улаанбаатар хотын ойролцоох үзэсгэлэнт онгон байгаль, эртний түүх, соёлын дурсгалт зүйлтэй танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Аялал жуулчлалын салбарын зорих үзмэрүүдийн тоо нэмэгдэж үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж байгаагийн нэг нь Цонжин болдог, 13 дугаар зуун цогцолбор юм.

Аялал рекреацийн нөөцийн үнэлгээний нэгтгэл

Эдийн засгийн бүсүүд	Хамрагдах аймгууд	Аялал рекреацийн төрөл	Аялал-рекреацийн нөөцийн гол бүтээгдэхүүний нэр төрөл	Чанарын оноо	Аймгийн дүн	Бүсийн дүн
Баруун бүс	Баян-Өлгий	Эко аялал жуулчлал	Ёлтын сав газар, Алтай таван богдын байгалийн цогцолбор газар, Потанины мөсөн гол, Бага ойгор-Цагаан салаа, Бага түргэний хүрхрээ, Хурган нуур, Толбо нуур,	4	13	53
		Олзворын ан	Аргаль угалз зэрэг ангийн нөөц ихтэй БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 15 бүс байдаг бөгөөд ангийн нөөц бүрэн тогтоогдоогүй, Баянзүрх, Төмөрт, Эзэрлэг зэрэг газруудад 2017 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн ба жилд 1-2 угалз агнуулах боломжтой	5		
		Түүх соёлын аялал жуулчлал	Казах, урианхай, тува, гэх улсуудын ёс зан заншил, Бүргэдийн ангийн соёл, хадны сүг зураг, буган чулуу хөшөө	3		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	“Ахсу” Цагаан голын рашаан	1		
	Говь-Алтай	Эко аялал жуулчлал	Ээж хайрхан, Сүтай, Бурхан бүүдай, Алаг хайрхан, Аж богд уул, дэлхийд нэн ховордсон мазаалай, бөхөн, хулан, хавтгай	2	9	
		Олзворын ан	Аж богдын ангийн бүс БОАЖЯ-нд бүртгэлтэй байгаа боловч ан зохион байгуулалт хийгдээгүй. Судалгаагаар янгир ямаа 4913 бодгаль, аргал 1556 бодгаль	4		
		Түүх соёлын аялал жуулчлал		1		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Бигэрийн элсэн сувилал	2		
	Завхан	Эко аялал жуулчлал	Отгонтэнгэр (4021метр), түүний салбар Тарвагатай, Хуримт, Түдэвтэй, Гурван Халтар, Гялгар, Булнайн нуруу, Монгол элс, Бор хярын элсэн манхнууд	1	9	
		Олзворын ан	Янгир ямааны нөөцтэй /13376бодигал/	2		
		Түүх соёлын аялал жуулчлал	Отгонтэнгэр, Улаан хаалга, Баянзүрх, Зарт, Хожуул, Улаан эрэг зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад хадны сүг зураг, буган чулуу, хүн чулуун хөшөө дурсгалууд, ХҮИИ зууны үеийн цэргийн цайз, худалдаа, наймааны хот, хүрээ, хийд дуган сүмийн түүрх	3		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Отгонтэнгэрийн рашаан	3		
	Увс	Эко аялал жуулчлал	Увс нуур, Хяргас нуур ба Хэцүү хад, Алтан элсний дархан цаазат газар, Ханхөхий уулс, Чандмань уулын дурсгал, Гоожуурын хүрхрээ, Мөнгөт цахир уул, Дэглий цагаан уул, Олон нуур	3	10	
		Олзворын ан	ОНТХ-нд Гулзат, УТХ-д Түргэний уулсаар ангийн нөөцтэй боловч агнуур зохион байгуулалт хийгээгүй, зөвшөөрөгдсөн ангийн бүс байхгүй	3		
		Түүх соёлын аялал жуулчлал	Хадны сүг зураг, хөшөө	2		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Хар тэрмэсийн рашаан устай.	2		
Ховд	Эко аялал жуулчлал	Хар-Ус, Хар, Дөргөн зэрэг том нуурууд, Цамбагарав уул, Булган гол, Хөх сэрхийн нуруу	3	12		
	Олзворын ан	Аргаль угалз зэрэг ангийн нөөц ихтэй БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 10 бүс байдаг бөгөөд 2-с бусдад нь 2017 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн ба жилд 2-3 угалз, Хажинга ангийн бүсэд 3-4 угалз агнуулах боломжтой	4			
	Түүх соёлын аялал жуулчлал	Захчин, мянгад, дөрвөд, урианхай, казак, торгууд, өөлд гэх мэт үндэстэн ястны соёл, Баянзүрхийн буган хөшөө, төрийн тахилгат Алтанхөхий уул, Ямаан усны хадны сүг зураг, Ишгэн толгойн хадны зураг, Цэнхэрийн агуй, Харуул овоо	3			
	Рашаан сувиллын аялал жуулчлал	Нэвтийн, Булганы, Индэртийн зэрэг рашаан	2			



Хангайн бүс	Архангай	Эко аялал жуулчлал	Чулуутын гол, Хоргын тогоо, Тэрхийн цагаан нуур, Суварга хайрхан уул, Тамирын гол, Булган уул, Тайхар чулуу,	4	14	76
		Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 6 бүс байдаг агнуур зохион байгуулалт хийгдээгүй, ангийн нөөц тодорхой бус. Мөн Тамир, Чулуут, Орхон голд тул загас	2		
		Түүх соёлын аялал жуулчлал	Гол модны Хүннү булш, Хар балгас, Билгэ хааны цогцолбор зэрэг Хиргисүүр, булш бунхан, хот балгадын туурь, гэрэлт хөшөө, хадны сүг зургаар баялаг	3		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Шивэрт, Цэнхэр, Мухар хужирт зэрэг халуун рашааны нөөц ихтэй	5		
	Баянхонгор	Эко аялал жуулчлал	Бүгийн цавын хоолой, Их богд уул болон Эхийн гол, Шар хулстай, Цагаан бургас, Хуцын шанд, Өлзийт гол, Бурхант, Бор овооны задгай, баруун зүүн Тоорой зэрэг үзэсгэлэнт Баянбүрдүүд	2	13	
		Олзворын ан	Аргаль угалз зэрэг ангийн нөөц ихтэй БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 8 бүс байдаг бөгөөд 2-с бусдад нь 2017 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн жилд 1 угалз, 2-3тэх, Улаан аргалант ангийн бүсэд 15 тэх агнуулах боломжтой гэсэн судалгаа байна	3		
		Түүх соёлын аялал жуулчлал	Чулуун зэвсэг, хүрлийн үеийн зэр зэвсэг, багаж хэрэгсэл гоёл чимэглэлийн зүйлс, хадны бичээс, дүрс, сүг зураг, бичигт хөшөө, буган чулуу, хүн чулуу. Цагаан агуй, Бичигт хад, Шатар чулуун хөшөө, Түрэгийн үеийн бичээс	3		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Шаргалжуутын рашаан	5		
	Булган	Эко аялал жуулчлал	Уран тогоо, Тулга, Бүрхээр, Жалавч зэрэг унтарсан галт уул	3	12	
		Олзворын ан	Эг, Сэлэнгэ мөрөн тул загас	2		
		Түүх соёлын аялал жуулчлал	Монголын анхны төрт улс болох Хүннү болон Нирун, Сяньби, Түрэг, Уйгарын хаант улс, Кидан, Киргыз зэрэг улсууд оршин тогтнож байсны ул мөр хөшөө дурсгал, Шивээт улааны цогцолбор, Хар бухын балгас, Чин толгойн балгас, Бийбулагийн туурь	3		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Хульж, Хануй, Их булгийн рашаан	4		
	Орхон	Эко аялал жуулчлал	Дайран өнгөрөх	1	4	
		Олзворын ан		1		
		Түүх соёлын аялал жуулчлал		1		
		Рашаан сувиллын аялал жуулчлал		1		
	Өвөрхангай	Эко аялал жуулчлал	Орхон голын хүрхрээ, Хүйсийн найман нуур, Элсэн тасархай	3	16	
		Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 2 бүс байдаг бөгөөд 2017 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн ба жилд 3 угалз, 3-4тэх агнуулах боломжтой гэсэн судалгаа байна	3		
		Түүх соёлын аялал жуулчлал	Хөшөө цайдам дахь Түрэгийн дурсгалууд, Ордубалык буюу Хар балгас, Хархорин хотын туурь, Эрдэнэ зүү хийд, Төвхөн хийд, мөн эртний хотын туурь, дөрвөлжин булш, Мэлхий чулуун дурсгал, буган чулуу түүх соёлын үл мөр бүхий газрууд	5		
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Хужирт, Могойтын рашаан	5		
Хөвсгөл	Эко аялал жуулчлал	Соёны бүс нутаг, Хөвсгөл нуур, Даян дээрхийн агуй	5	17		
	Олзворын ан	Тэнгис, Шишгэд, Шарга, Эг, Үүр, Дэлгэрмөрөн, Олон голын бэлчир, Сэлэнгэ, Идэр-Чулуут голд тул загас	4			
	Түүх соёлын аялал жуулчлал	Монголын бөө удгануудын өлгий нутаг, Уушгийн өврийн буган чулуу, Улаан толгойн буган хөшөө, дархадын 13 овоо, Цаатны нутаг	4			
	Рашаан сувиллын аялал жуулчлал	Салбарт, Булнайн рашаан	4			



Төвийн бүс	Говьсүмбэр	Эко аялал жуулчлал	Чойрын богд уул	1	6
		Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 1 бүс байдаг бөгөөд 2017 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн ба 2 угалз агнуулах боломжтой гэсэн судалгаа байна	2	
		Түүх соёлын аялал жуулчлал	Чойрын хийдийн туурь, Цагаан дарь эхийн хадан хөрөг, Дагвасүндэл бурхны хөрөг, Хүүхдийн овоо, Дугар мээрэнгийн хөшөө	2	
		Рашаан сувиллын аялал жуулчлал		1	
	Дархан-Уул	Эко аялал жуулчлал	Дайран өнгөрөх	1	4
		Олзворын ан		1	
		Түүх соёлын аялал жуулчлал	Шарын голын зосон зураг, Буурал уулын булш, Лам Дондовын рашаан, Хүйтний голын хадны бичээс	1	
		Рашаан сувиллын аялал жуулчлал		1	
	Дорноговь	Эко аялал жуулчлал	Сүйхэнтийн ой, Цонжийн чулуу, Бүдэнэ булаг, Цагаан дэлийн агуй, мөн 80 гаруй сая жилийн тэртээ амьдарч байсан үлэг гүрвэлийн чулуужсан яс, далай, тэнгисийн амьтан, ургамлын үлдэгдэл, чулуужсан мод,	2	13
		Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 4 бүс байгаа бөгөөд 2017 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн тайлангаас үзэхэд Хутаг уул жил бүр 3-4угалз, Хатны булаг, Таван баян нийт 8 угалзын нөөцтэй байна. Ангийн нөөц тодорхой бүс 1 бүс байна.	4	
		Түүх соёлын аялал жуулчлал	Хамрын хийд, Хуучин ба дунд, шинэ чулуун зэвсэг, хадны сүг зураг, хүрлийн болон төмрийн үеийн зэр зэвсэг, булш бунхан, гэрэлт хөшөө, хот балгадын туурь	3	
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Халзан уулын рашаан	4	
	Дундговь	Эко аялал жуулчлал	Их бага газрын чулуу, Өөш манхан, Цагаан суварга, Дэлгэрийн Чойр, Сангийн далай	3	11
		Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 1 бүс байгаа бөгөөд нөөц тодорхой бүс байна. Судалгаагаар аргаль 1338 бодгаль, янгир 1518 бодгаль	3	
		Түүх соёлын аялал жуулчлал	Шарангадын Монгол бичигт агуй, Зараа бугын хөшөө, Дэл уулын 32 хүн хөшөөтэй булш, Ар зүлэгтийн дөрвөлжин булш	2	
		Рашаан сувиллын аялал жуулчлал	Өөшийн элсэн сувилал	3	
	Өмнөговь	Эко аялал жуулчлал	Говь гурван сайхан уул, Баянзаг, Нэмэгт уул ба Хэрмэн цав, Галбын говь, Ноён богд ба Толь хад, Алгуй улаан цав, Хонгорын элс, Сангийн далай	5	15
		Олзворын ан	Аргаль 2404 бодгаль, Янгир 13324 бодгаль	5	
		Түүх соёлын аялал жуулчлал	Хүннүгийн үеэс XIII, XIV зууны үед хамаарах 10 гаруй хот балгас, 20 орчим цэргийн хамгаалалтын байрууд, 300 гаруй хиргисүүрийн дурсгал бий. Гурвантэс сумын Хавтын бунхан, эртний амьтны олдвор	4	
		Рашаан сувиллын аялал жуулчлал		1	
Сэлэнгэ	Эко аялал жуулчлал	Соронзон хад, Хувьсгалын өлгий Алтанбулаг, Халуун рашаан, Түжийн нарс, Дуут хад, Сайханы хөтөл, Ээж мод	3	10	
	Олзворын ан	Дотоодын аялал жуулчлалд Гахай, загас зэрэг спорт агнуур хөгжүүлэх боломжтой	2		
	Түүх соёлын аялал жуулчлал	Амарбаясгалант хийд, Ноён уул, бичигт хад мөн 1921 онд Ардын хувьсгалын анхны ялалт Сэлэнгэ аймагт болж, Шивээ хиагт, Шаамарын шар тохой, Улаанбургас, Ханын хөндий, Зэлтэр зэрэг тулалдаанууд түүхэнд тэмдэглэгдэн үлдэж, ардын журамт цэргийн байрлаж, бүтэц зохион байгуулалтаа шийдвэрлэж байсан Ханын хөндий, Номт, Эрээн арал, Алтан зэрэг газрууд түүх соёлын дурсгалт газар болон үлджээ	3		
	Рашаан сувиллын аялал жуулчлал	Рашааны нөөц бий	2		
Төв	Эко аялал жуулчлал	Хустайн байгалийн цогцолборт газар, Зоргол хайрхан уул, Тэрэлж, Хагийн хар нуур	3	14	
	Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 7 бүс байна. 2017-2019 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн тайлангаас үзэхэд жилд 1-2 угалз, 5-8 буга. Ангийн нөөц тодорхойгүй 1 бүс байна.	3		
	Түүх соёлын аялал жуулчлал	Манзуширын хийдийн туурь, Гүнжийн сүм, Аглаг бүтээлийн хийд, Чингис хааны морьт хөшөө, Тоньюкукын гэрэлт хөшөөний бичээс, Цогт хунтайжийн дуутын хадны бичээс, Ээж хад	3		
	Рашаан сувиллын аялал жуулчлал	Ар, Өвөр жанчивлангийн рашаан	5		

73



Зүүн бүс	Дорнод	Эко аялал жуулчлал	Халхгол-Нөмрөг, Буйр нуур,	2	9	30
		Олзворын ан	Халхгол, Онон, Хэрлэн голд тул загас	2		
Түүх соёлын аялал жуулчлал	Хэрлэн бар хот, Хэрмэн зам, XIX зууны үед хүний гараар бүтээгдсэн Утай таван уул, Их бурхант, хүн чулуунууд, Угтамын хийдийн туурь, Халх голын ялалтын хөшөөнүүд	3				
Рашаан сувиллын аялал жуулчлал	Утаат минчүүр халуун уур хийн рашаан бүрэн судлагдаагүй	2				
Сүхбаатар	Эко аялал жуулчлал	Шилийн богд, Алтан-Овоо, Зотолхан уул, Ганга нуур, талын агуй, Оргихын булаг	1	7		
	Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 2 бүс байгаа бөгөөд 2018 он хүртэлх хугацааны ангийн зохион байгуулалт хийгдсэн тайлангаас үзэхэд ангийн бүс тус бүрээс жилд 1-2 угалз агнуулах нөөцтэй байна.	2			
	Түүх соёлын аялал жуулчлал	Төрийн тахилгат Алтан овоо, Шилийн богд, эртний үеийн түүхийг хүүрнэсэн хүн чулуу	3			
	Рашаан сувиллын аялал жуулчлал		1			
Хэнтий	Эко аялал жуулчлал	Хан хэнтийн дархан газар, Онон, Хэрлэн голын сав газар	2	14		
	Олзворын ан	БОАЖЯ-нд бүртгэлтэй ангийн 17 бүс байгаа бөгөөд Язаарын уул, Дэлгэрхаан тус бүр жилд 1-2 угалзын нөөцтэй, бусад ангийн бүс гахай, гөрөөсний ангийн нөөцтэй байна. Онон, Хэрлэн тул загас	3			
	Түүх соёлын аялал жуулчлал	Монгол улсын төрийн тахилгат Бурхан Халдун уул, Дэлүүн болдог, Даланбалжуд, Чингисийн хөшөө, Биндэр уул, Хурхын хөндий, Аураг орд, Аваргын балгас, Хар зүрхний хөх нуур, Номын гэрэлт хөшөө, Жаргалант нуурын бичигт хад, Өглөгчийн хэрэм, Рашаан хадны булш, Рашаан хадны сүг зураг	5			
	Рашаан сувиллын аялал жуулчлал	Гурван нуур, Аварга тосон болон Ононгийн халуун рашаан	4			
Улаанбаатарын бүс	Эко аялал жуулчлал	Хот орчмын амралт зугаалгын бүсүүд	1	12	12	
	Олзворын ан		1			
	Түүх соёлын аялал жуулчлал	Богд хааны ордон, Сүм хийдүүд, Музей	5			
	Рашаан сувиллын аялал жуулчлал	Оргилын рашаан болон бусад сувиллын газрууд	5			

Аялал рекреацийн нөөцийн чанарын үнэлгээний нэгтгэл

Бүсийн нэр	Бүсэд байх аймгийн тоо	Эко аялал жуулчлал			Олзворын ан			Түүх соёлын аялал жуулчлал			Рашаан сувиллын аялал жуулчлал		
		Нийт оноо	Нэг аймагт ногдох оноо	Эрэмбэ	Нийт оноо	Нэг аймагт ногдох оноо	Эрэмбэ	Нийт оноо	Нэг аймагт ногдох оноо	Эрэмбэ	Нийт оноо	Нэг аймагт ногдох оноо	Эрэмбэ
Баруун бүс	5	13	2.60	2	18	3.60	1	12	2.40	5	10	2.00	5
Хангайн бүс	6	18	3.00	1	15	2.50	3	19	3.17	3	24	4.00	2
Төвийн бүс	7	18	2.57	3	20	2.86	2	18	2.57	4	17	2.43	3
Зүүн бүс	3	5	1.67	4	7	2.33	4	11	3.67	2	7	2.33	4
Улаанбаатарын бүс	1	1	1.00	5	1	1.00	5	5	5.00	1	5	5.00	1
Дүн	22												

Аялал рекреацийн нөөцийн чанарын үнэлгээг аймаг бүсүүдийн нөөц байдлыг хооронд нь харьцуулж, харьцуулсан үнэлгээний аргаар баллаар үнэлж боловсруулав.



Аялал рекреацийн нөөцийн үнэлгээнд тулгуурласан бүсчлэл



Аялал рекреацийн ерөнхий бүсчлэл

Аялал рекреацийн ерөнхий бүсчлэл	Талбай мян.га	Хамрагдах газар нутаг
Тэргүүлэх чиглэл нь экосистемийн үйлчилгээнд суурилсан аялал рекреаци болон түүх соёлын аялал жуулчлалын холимог бүс	119398.5	Монгол Улсын нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг хамрах бөгөөд тус 2 төрлийн аялал жуулчлалын нөөцүүд хоорондоо ялгах боломжгүйгээр тархан байршсан тул холимог бүс болгон зураглав.
Тэргүүлэх чиглэл нь олзворын ан, түүх соёлын нөөцөд тулгуурласан аялал рекреацийн бүс нутаг	36860.6	Олзворын ангийн нөөц бүхий БОАЖЯ-нд бүртгэлтэй менежментийг хариуцагч байгууллагатай ангийн бүс бүхий нутаг дэвсгэрийг хамруулсан бөгөөд Баян-Өлгий, Увс аймгийн баруун хэсэг, Ховд аймгийн урд хэсэг, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Алтайн нуруунд хамаарах хэсэг, Төв аймгийн урд сумууд болон Дорноговь, Сүхбаатар, Дундговь аймгуудын зарим сумдууд хамрагдана
Тэргүүлэх чиглэл нь рашаан, сувиллын нөөцөд тулгуурласан аялал рекреацийн бүс	1309.2	Монгол орны рашаан усны томоохон нөөц бүхий Хангайн нуруу болон улсын болон бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг рашаан сувиллын газруудыг хамруулав.
Дүн	157568.2	

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Байгалийн аялал жуулчлалын чиглэлээр тэргүүлэх ач холбогдол өгч, бие даасан бүтээгдэхүүн болгож гадаадын жуулчдын анхаарлыг татах, аялах эрхийн тусгай зөвшөөрлөөр онгон байгальд аялах боломжит бүс газар Хөвсгөл аймгийн Улаан тайгын ДЦГ-ын Хорьдол, Сарьдагийн нуруу, Улаантайга, Тэнгис-Шишгэдийн голын БЦГ, Баян-Өлгий аймгийн Алтай таван Богдын ДЦГ-ын мөнх цас, мөсөн гол зэрэг газруудад онгон



байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. мөн “Үндэсний геопаркын сүлжээ байгуулах судалгаа хийх” арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

Тусгай зөвшөөрөл бүхий байгалийн аялал жуулчлал:

1. Тусгай зөвшөөрөл бүхий байгалийн аялал жуулчлал нь нийтлэг түгээмэл аялал, тусгай зөвшөөрлийн/лицензийн аялал гэж ангилагддаг байна. Нийтлэг түгээмэл аялалд ТХГН-ийн зөвшөөрөгдсөн бүс болон бусад газарт /байгальд/ аялах бүх эко аялал ордог байна.
2. ТХГН-ийн аялал жуулчлалын зөвшөөрөгдсөн бүсэд геологийн өвөрмөц тогтоц, байгалийн дурсгал бүхий хүний сонирхлыг татах өндөр түвшний (высокая аттрактивность) газруудыг хамруулна.
3. Тусгай зөвшөөрөл бүхий байгалийн аялалд ТХГН-т ихэвчлэн явагддаг, огт хөндөгдөөгүй эсвэл маш бага хөндөгдсөн байгалийн иж бүрдэл, геологийн өвөрмөц тогтоц, байгалийн дурсгал бүхий хүний сонирхлыг татах өндөр түвшний (высокая аттрактивность) онгон газар нутаг, усны мандал (акваторий) дахь аяллын зөвшөөрлийн тодорхой хугацааны давтамжтайгаар (5 жилд 1 удаа гэх мэт) аялах эрхийн тусгай зөвшөөрөлтэй, аялагчдын тооны хязгаарлалттай, экологийн танин мэдэхүйн аяллууд ордог байна.



Хамгаалж хадгалсан газар дахь тусгай зөвшөөрөл бүхий байгалийн аялал жуулчлал:




ТХГН-ийн онцгой бүсэд ихэвчлэн явагддаг, огт хөндөгдөөгүй эсвэл маш бага хөндөгдсөн байгалийн иж бүрдэл, геологийн өвөрмөц тогтоц бүхий онгон дагшин газар нутагт (акваторий) аяллын зөвшөөрлийн тодорхой хугацааны давтамжтайгаар (5 жилд 1 удаа) аялах эрхийн тусгай зөвшөөрөлтэй, аялагчдын тооны хязгаарлалттай, экологийн танин мэдэхүйн аяллыг ойлгоно.

Хамгаалж хадгалсан байгаль дахь байгалийн аялал жуулчлал нь экотуризмын сонгодог (классик) чиглэл бөгөөд нэр томъёоны явцуу утгаараа “Австралийн” эсвэл “Хойд Америкийн” экотуризмын загвар гэж нэрлэгддэг. Манай оронд ашиглалтгүй онгон зэрлэг газар бараг үгүй бөгөөд ийм газрын ихэнх нь ТХГН-ийн сүлжээнд хамрагдсан байна.

Байгалийн аялал жуулчлалын чиглэлээр тэргүүлэх ач холбогдол өгч, бие даасан бүтээгдэхүүн болгож гадаадын жуулчдын анхаарлыг татах, аялах эрхийн тусгай зөвшөөрлөөр аялах боломжит бүс газарт дараах газрууд орно. Хөвсгөл аймгийн Улаан тайгын ДЦГ-ын Хорьдол, Сарьдагийн нуруу, Улаантайга, Тэнгис-Шишгэдийн голын БЦГ, Баян-Өлгий аймгийн Алтай таван Богдын ДЦГ-ын мөнх цас, мөсөн гол зэрэг газруудад тусгай зөвшөөрөл бүхий байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Тусгай зөвшөөрөл бүхий байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх бүсүүд






- Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн түүхэн суут хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой газар нутаг, архитектурын дурсгал болон түүх соёлын үл хөдлөх дурсгал, соёлын өвийг хамгаалах, нөхөн сэргээх, шинээр бүтээн байгуулах замаар хөрөнгө оруулалт хийж дэлхий, бүс нутгийн хэмжээний аялал жуулчлалын өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн болгож эдийн засгийн эргэлтэд оруулах /6-н байршил дахь эко аялал жуулчлалын цогцолбор, Чингис хааны цогцолбор, Эртний хот Хархорин, Баянзагийн эртний соёлын дурсгал, угсаатны соёлын цогцолборуудыг төлөвлөсөн/



Эко аялал жуулчлалын цогцолборууд



Эко аялал жуулчлалын тэргүүлэх чиглэл:

1. Экотуризмын үр нөлөө нь ашиг орлогод биш, байгаль хамгаалалд тэргүүлэх ач холбогдол өгөх,
2. Жуулчдын сэтгэл ханамж, таашаалыг хангахад тэргүүлэх ач холбогдол өгөх,
3. Экотуризмыг сурталчлах, маркетинг, менежментэд орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлэх, үзэсгэлэн худалдаа, сургалт, хурал семинарыг тогтмолжуулахад тэргүүлэх ач холбогдол өгөх,
4. Экотуризмыг дагалдан кластераар гар урлал, газарчин-хөтөч, гэр отог, буудал, хоолны газар, ахуй зан үйлийн үйлчилгээ зэрэг бусад үйлдвэрлэл, үйлчилгээг кластер хэлбэрээр цогцоор хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх,
5. Экотуризмыг байгалийн болон соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, арчлах, үндэсний зан заншил, соёлыг сэргээн хөгжүүлэх, төлөвшүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх,

Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарах бодлогын гол чиглэл:

Эдийн засгийн бодлогын чиглэл:

1. Рекреацийн нөөцийг ашиглаж аж ахуйн үйл ажиллагаанаас олсон ашиг орлогын татвар болон нөөц ашиглах эрхийн төлбөрүүдээс тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн орлогыг бүрдүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн төр захиргааны байгууллага өөрийн нутаг дэвсгэртээ эзэн байх, нөөцөө үр ашигтай, зүй зохистой ашиглах сонирхол, эрх үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд экотуризмын эдийн засгийн бодлогыг чиглүүлэх;



2. Эко аялал жуулчлалын олон улсын болон үндэсний хэмжээний томоохон сүлжээ байгуулж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг олон улсын стандартад нийцүүлж Монгол орныг таних брендүүд бий болгож өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж нөхөн сэргээгдэх баялгаас олох валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх (буцаан олгох барьцааны схем, хөнгөлөлттэй тариф, зээлийн хүүг бууруулах хөтөлбөр, экотуризмыг хөгжүүлэх орон нутгийн сан байгуулах гэх мэт);
3. Газар, рекреацийн нөөцийг үнэлж актив хөрөнгийн хэлбэрт шилжүүлж газрын кадастр, төрийн өмчид бүртгэж зах зээлийн эдийн засгийн арга, механизмаар удирдах бодлогыг хэрэгжүүлэх;
4. Аялал жуулчлал эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн экотуризмаас олсон орлогоос байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, нутгийн иргэдийг ажилтай орлоготой байлгах нийгмийн хариуцлагыг хэмжих, дүгнэх, гадаад, дотоодод нэр хүндийн илэрхийлэл болгох мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

Байгаль орчны бодлогын чиглэл:

1. Эко аялал жуулчлалд олон улсын зарчим, хандлага, соёлыг нэвтрүүлэх, ялангуяа Монгол Улсын иргэдийн одоогийн аялж, жуулчилж буй буруу ойлголт, хандлага, бүдүүлэг, соёлгүй байдлыг өөрчилж байгальд ээлтэй аяллыг тухайн хүний нэр хүнд, ухамсар, соёл, боловсролын түвшний үзүүлэлт, нийгэмд эзлэх байр суурийн илэрхийлэл байх нийгмийн сэтгэл зүйн төлөвшлийг бүрдүүлэх;
2. Эко аялал жуулчлалыг газрын доройтол, орчны бохирдолгүй болон сөрөг нөлөөллийг бууруулах, ачаалал, багтаамжийг зохицуулах хууль, эрх зүй, хяналтын оновчтой нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, рекреацийн нөөц ашигласны болон түүнд учирсан хохирлын нөхөн төлбөр зэрэг эдийн засгийн механизм, арга хэрэгслийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх;
3. Газрын доройтол, орчны бохирдол, ачааллыг багасгах зорилгоор аялал жуулчлалын үндэсний болон бүс нутгийн хэмжээний цогцолборыг байгуулах голлох аяллын маршрутыг эдийн засгийн бүс бүрээр тогтоох;

Нийгмийн бодлогын чиглэл:

1. Аялал жуулчлал болон нийгмийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт дараах асуудлуудыг тусгаж хэрэгжүүлэх
2. Нутгийн иргэдийн экотуризмыг эрхлэхэд оролцох, ажлын байр бий болгоход чиглэсэн гар урлал, газарчин-хөтөч, гэр отог, кемп, буудал, хоолны газар ажиллуулах, ахуй зан үйлийн үйлчилгээ, тогооч, бармен зэрэг мэдлэг, чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх, дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
3. Хөдөө орон нутагт нийгмийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, хэрэгцээт бараа, үйлчилгээний чиглэлээр нутгийн иргэд бизнес эрхлэх;
4. Эко аялал жуулчлалын чанартай үйлчилгээ нь тухай орон нутагт үйлчилгээний чанартай, соёлтой байдлыг төлөвшүүлэх хүчин зүйл болох;
5. Хөдөө орон нутаг дахь соёлын өв, дурсгалыг хадгалах, арчилж тордох, нөхөн сэргээх; (уламжлал, зан заншил, гар үйлдвэр, урлал, байгаль, түүхийн дурсгал, шашин, соёл гэх мэт)



Төлөвлөсөн эко аялал жуулчлалын цогцолбор, түүний бүрдэл хэсэг, үндсэн элементүүд

№	Цогцолборын төслийн нэр	Бүрэлдэхүүн хэсэг	Гол элементүүд, тэдгээрийн газар ашиглалтын төрөл	Байршил	Солбицол	
					X	Y
1	Аялал жуулчлалын "Хөвсгөл" цогцолбор	Зочид буудал, отелийн хэсэг	Зочид буудал, отелийн барилга, байгууламж	Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны төв	100° 10' 28.051" E 50° 26' 34.240" N	
		Нийтийн үйлчилгээний барилга, байгууламж	Архитектурын өвөрмөц шийдэл бүхий мэдээлэл, худалдаа, үйлчилгээ, нийтийн цэнгээн, энтертайментийн ордны барилга, нийтийн халуун усны барилга, биеийн тамир спортын талбай, зам, авто зогсоол			
		Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, хангамж	Нэгдсэн уурын зуух, цэвэр, бохир ус, халуун ус, цэвэрлэх байгууламж			
			Эрчим хүч, холбоо, мэдээллийн байгууламж, хангамж			
		Цэцэрлэг хүрээлэн хиймэл ландшафтын хэсэг	Цэцэрлэгт хүрээлэн, аттрикцион, аллея, усалгааны байгууламж			
2.	"Алтай таван богд" бүргэдийн ан, эко аяллын үйлчилгээний цогцолбор,	Ханх сумын хилийн боомтын жуулчдын дамжин өнгөрөх бүсэд худалдаа, "Эв модны наадам" мэдээлэл, худалдаа үйлчилгээний төв.	Мэдээлэл, худалдаа, үйлчилгээний төвийн барилга, халуун усны барилга, дэд бүтэц, төвлөрсөн бүс шугам сүлжээ, байгууламж, зам, авто зогсоол	Хөвсгөл аймгийн Ханх сум	100° 42' 48.537" E 51° 31' 38.481" N	
		Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвд "Цаатан иргэдийн мэдээлэл, үйлчилгээний төв"	Мэдээлэл, худалдаа, зочид буудал, үйлчилгээний төвийн барилга, дэд бүтэц, төвлөрсөн инженерийн байгууламж	Хөвсгөл аймгийн Цагааннуур сум		99° 21' 1.696" E 51° 21' 18.843" N
		Уйгар, Казак иргэдийн түүх, соёлын өвийн мэдээлэл, үйлчилгээний төв.	Үндэсний онцлог бүхий архитектурын шийдэл түүх, соёлын өвийн мэдээлэл, үйлчилгээний төвийн барилга, зам, авто зогсоол, халуун усны барилга	Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын төвд		
		Зочид буудал, отелийн цогцолбор	Зочид буудал, отелийн барилга байгууламж			
		Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, хангамж	Нэгдсэн уурын зуух, цэвэр, бохир ус, халуун ус, цэвэрлэх байгууламж Эрчим хүч, холбоо, мэдээллийн байгууламж	Хурган нуур, Цагаан голд	88° 24' 51.763" E 48° 35' 40.352" N 88° 28' 15.394" E 49° 06' 10.183" N	
		Цэцэрлэгт хүрээлэн хиймэл ландшафтын хэсэг	Ой, амрах зугаалах зам, талбай, аллея, усалгааны байгууламж			
		малчдын гэр кемп	Гэр, хоолны газар, эко бие засах газар			



3	“Хар ус нуур” цогцолбор	Зочид буудал, отелийн хэсэг	Зочид буудал, отель хүүхдийн зуслангийн байр барилга байгууламж	Хар ус нуурын эрэг	92° 1' 6.627" E 47° 50' 52.823" N
		Наран шарлагын хэсэг	Усан сэлэх усан гадаргуугийн талбай, наран шарлагын талбай, хамгаалалтын ойн зурвас, тоглоомын талбай.явган хүний зам, хувцас хадгалах, бие засах газар, машины зогсоол,		
		Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, хангамж	Бие даасан төвлөрсөн бус цэвэр, бохир ус, халуун ус, цэвэрлэх байгууламж		
			Эрчим хүч, холбоо, мэдээллийн байгууламж		
Цэцэрлэгт хүрээлэн, хиймэл ландшафтын хэсэг	Ой, амрах зугаалах зам, талбай, аллея, аттрикцион, усалгааны байгууламж				
4	“Хорго-Тэрх” цогцолбор	Мэдээлэл, худалдаа үйлчилгээний хэсэг	Архитектурын өвөрмөц шийдэл бүхий мэдээлэл, худалдаа, үйлчилгээ, нийтийн цэнгээн, энтертайментийн ордны барилга, зам, авто зогсоол, халуун ус	Тэрхийн цагаан нуур	99° 48' 6.822" E 48° 11' 28.773" N
		Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, хангамж	Бие даасан төвлөрсөн бус цэвэр, бохир ус, халуун ус, цэвэрлэх байгууламж		
		Цэцэрлэг хүрээлэн хиймэл ландшафтын хэсэг	Цэцэрлэгт хүрээлэн, аллея, усалгааны байгууламж		
5	Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвд “Алтан Овоо” төсөл.	Мэдээлэл, худалдаа үйлчилгээний цогцолбор	Архитектурын өвөрмөц шийдэл бүхий мэдээлэл, худалдаа, үйлчилгээ, нийтийн цэнгээн, энтертайментийн ордны барилга зам, авто зогсоол	Зэгст нуурын амралт	113° 50' 10.785" E 45° 17' 26.621" N
		Зочид буудал, отелийн цогцолбор	Хүүхдийн зуслангийн байр, зочид буудал		
		Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, хангамж	Нэгдсэн уурын зуух, цэвэр, бохир ус, халуун ус, цэвэрлэх байгууламж		
			Эрчим хүч, холбоо, мэдээллийн байгууламж		
Цэцэрлэг хүрээлэн хиймэл ландшафтын хэсэг	Цэцэрлэгт хүрээлэн, аттрикцион, аллея, усалгааны байгууламж				
6	“Увс нуур” “наран шарлагын цогцолбор	Худалдаа, үйлчилгээний цэг	Дэлгүүр, эрүүл мэнд, аврах ажиллагааны үйлчилгээний цэг	Увс нуурын эрэг	92° 23' 47.342" E 50° 7' 9.631" N
		Наран шарлагын хэсэг	Усан сэлэх усан гадаргуугийн талбай, наран шарлагын талбай, хамгаалалтын ойн зурвас, тоглоомын талбай.явган хүний зам, хувцас хадгалах, бие засах газар, машины зогсоол		



Түүх соёлын дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөлт

Түүх соёлын аялал жуулчлал хөгжүүлэх газар нутгийн газар зохион байгуулалт, шийдвэрлэх ерөнхий асуудлууд:

Стратегийн зорилт: Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн түүхэн суут хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой газар нутаг, архитектурын дурсгал болон түүх соёлын үл хөдлөх дурсгал, соёлын өвийг хамгаалах, нөхөн сэргээх, шинээр бүтээн байгуулах замаар хөрөнгө оруулалт хийж дэлхий, бүс нутгийн хэмжээний аялал жуулчлалын өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн болгож эдийн засгийн эргэлтэд оруулах. Түүх соёлын өвийг хадгалж ирсэн нутаг дэвсгэр нь дэлхий, бүс нутгийн хэмжээнд, улс үндэсний хэмжээнд онцгой үнэ цэнтэй газарт тооцогддог. Ийм газрыг зохистой, үр ашигтай ашиглаж, хамгаалахын тулд улсын ГЗБЕТ-нд дараах үндсэн гол асуудлуудыг тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөв. Түүх соёлын аялал жуулчлалын нөөц бүхий газрыг ач холбогдлоор нь дараах чиглэлээр эрэмбэлж тогтоов.

Түүх соёлын аялал жуулчлалын тэргүүлэх чиглэл:

- Дэлхийн Мянганы хүнээр нэрлэгдсэн Чингис хааны төрж өссөн болон хаан ширээнд суусан газар нутаг, түүх соёлын биет бус баримтуудыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, алдаршуулах цогцолборыг байгуулж эдийн засгийн эргэлтэд оруулахад тэргүүлэх ач холбогдол өгөх,
- Хархорины түүх соёлын өв дурсгал, түүхэн баримтуудыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, алдаршуулах цогцолборыг байгуулж эдийн засгийн эргэлтэд оруулах,
- Хүннү гүрний холбогдолтой археологийн олдвор бүхий газар нутаг, түүх соёлын үл хөдлөх эд өлгийн зүйл, эртний амьтны палеонтологийн олдвор бүхий газар нутаг, үл хөдлөх эд өлгийн зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх, уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал бүхий архитектурын чуулгатай хослуулсан цогцолборыг байгуулж эдийн засгийн эргэлтэд оруулахад тэргүүлэх ач холбогдол өгөх,
- Биет бус соёлын өвүүдийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож эдийн засгийн эргэлтэд оруулахад тэргүүлэх ач холбогдол өгөх,
- Түүх соёлын аялал жуулчлал нь эхний ээлжид орон нутгийн хөгжлийг дэмжих, төсвийн орлогыг бүрдүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх,

Эдийн засгийн бодлогын чиглэл, шийдэл:

- Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн нөөц ашиглаж аж ахуйн үйл ажиллагаанаас олсон ашиг орлогын татвар, нөөц ашиглах эрхийн төлбөрүүдээс тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн орлогыг бүрдүүлэх замаар орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байр бий болгох, орон нутгийн төр захиргааны байгууллага өөрийн нутаг дэвсгэртээ эзэн байх, нөөцөө үр ашигтай, зүй зохистой ашиглах сонирхол, эрх үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхэд түүх, соёлын аялал жуулчлалын эдийн засгийн бодлогыг чиглүүлэх, онцгой үнэ цэнтэй түүх соёлын аялал жуулчлалын нөөц бүхий газрыг олон улсын болон үндэсний түвшинд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Түүх, соёлын аялал жуулчлалын олон улсын болон үндэсний хэмжээний томоохон сүлжээ байгуулж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг олон улсын стандартад нийцүүлж Монголыг таних брендүүд бий болгож өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж нөхөн сэргээгдэх баялгаас олох валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх. (буцаан олгох барьцааны схем, хөнгөлөлттэй тариф, зээлийн хүүг бууруулах хөтөлбөр, түүх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутгийн сан байгуулах гэх мэт);



- Газар, түүх соёлын үл хөдлөх дурсгалын нөөцийг үнэлж актив хөрөнгийн хэлбэрт шилжүүлж газрын кадастр, төрийн өмчид бүртгэж зах зээлийн эдийн засгийн арга, механизмаар удирдах бодлогыг хэрэгжүүлэх;
- Аялал жуулчлал эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн түүх, соёлын аялал жуулчлалаас олсон орлогоос байгаль орчин, түүх соёлын өвийг хамгаалах нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх, нутгийн иргэдийн ажилтай орлоготой байлгах нийгмийн хариуцлагыг хэмжих, дүгнэх, гадаад, дотоодод нэр хүндийн илэрхийлэл болгох мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

Байгаль орчны бодлогын чиглэл, шийдэл:

- Түүх, соёлын аялал жуулчлалд олон улсын зарчим, хандлага, соёлыг нэвтрүүлэх, ялангуяа Монгол улсын иргэдийн одоогийн аялж, жуулчилж буй буруу ойлголт, хандлага, бүдүүлэг, соёлгүй байдлыг өөрчилж байгаль ээлтэй аяллыг тухайн хүний нэр хүнд, ухамсар, соёл, боловсролыг түвшний үзүүлэлт, нийгэмд эзлэх байр суурийн илэрхийлэл байх нийгмийн сэтгэл зүйн төлөвшлийг бүрдүүлэх;
- Түүх, соёлын аялал жуулчлалаас үүдэлтэй газрын доройтол, орчны бохирдлын сөрөг нөлөөллийг бууруулах, ачаалал, багтаамжийг зохицуулах хууль, эрх зүй, хяналтын оновчтой нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, түүх, соёлын өвийн нөөц ашигласны болон түүнд учирсан хохирлыг нөхөн төлбөр зэрэг эдийн засгийн механизм, арга хэрэгслийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх;
- Газрын доройтол, орчны бохирдлыг багасгах зорилгоор түүх, соёлын аялал жуулчлалын бүс нутагт өрсөлдөх болон үндэсний хэмжээний цогцолборыг байгуулахдаа инженерийн зам, шугам сүлжээ, ногоон байгууламж байгуулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх;

Нийгмийн бодлогын чиглэл, шийдэл:

- Түүх, соёлын аялал жуулчлал болон нийгмийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт дараах асуудлуудыг тусгаж хэрэгжүүлэх
- Нутгийн иргэдийг түүх, соёлын аялал жуулчлалын эрхлэхэд оролцох, ажлын байр бий болгоход чиглэсэн орчуулагч-хэлмэрч, гар урлал, үндэсний хувцас, соёлын зүйл үйлдвэрлэх, уламжлалт гар үйлдвэрлэл, газарчин-хөтөч, гэр отог, буудал, хоолны газар ажиллуулах, ахуй зан үйлийн үйлчилгээ, тогооч, бармен зэрэг мэдлэг, чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөдөө орон нутагт нийгмийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, ханган нийлүүлэх хэрэгцээт бараа, үйлчилгээний чиглэлээр нутгийн иргэд бизнес эрхлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Орон нутагт бизнес орчны хүрээнд ардын уламжлалт, үндэсний урлаг уран сайхан, сонгодог болон үндэсний хөгжим, бүжгийн чуулга, хамтлаг, хувь хүний тоглолт, циркийн үзүүлбэр үзүүлэх, хэл соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- Түүх, соёлын аялал жуулчлалаас төлөвшиж буй чанартай үйлчилгээ, мэдлэг мэдээлэл нь нь тухай орон нутагт үйлчилгээний салбарын чанартай, соёлтой байдлыг төлөвшүүлэх, соёл, боловсролын мэдлэгийг нэмэгдүүлэх хүчин зүйл, нөлөөлөл болгох, чадавхжуулах;
- Хөдөө орон нутаг дахь түүх, соёлын өв, дурсгалыг хадгалах, арчилж тордох, нөхөн сэргээх; (уламжлал, зан заншил, гар үйлдвэр, урлал, байгаль, түүхийн дурсгал, шашин, соёл гэх мэт)
- Рекреацийн бүс дэх экотуризмын эдийн засгийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх;
- Эко аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг татах;
- Хөдөө орон нутаг дахь аялал-рекреацийн нөөц, ТХГН-ийн ашиглалт, хамгаалалтын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх;
- Аялал жуулчлалын удирдлагын системд хөдөө орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд эдийн засгийн урамшууллын арга хэрэгслийг нэвтрүүлэх. (буцаан олгох



барьцааны схем, хөнгөлөлттэй тариф, зээлийн хүүг бууруулах хөтөлбөр, экотуризмыг хөгжүүлэх орон нутгийн сан байгуулах гэх мэт);

- Төр хувийн хэвшилд суурилсан экотуризмыг дэмжсэн үр ашигтай аялал жуулчлалын үйл ажиллагаа, олон улс, үндэсний, бүс нутгийн хэмжээний маркетингийн үйлчилгээг сурталчилсан нэгдсэн мэдээллийн систем байгуулах;

Түүх соёлын аялал жуулчлалд баримтлах зарчим:

- ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенц, Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенц, Олон улсын аялал жуулчлалын холбооны хүрээнд баримталдаг зарчмуудыг агуулга, санааны хувьд мөрддөг байх,
- Түүх соёлын өвийг хадгалан хамгаалахад идэвхтэй хамтын оролцоотой байх,
- Түүх соёлын гайхамшигт өв нь бусад газраас ялгарах, тодорхойлогдох харьцангуй үнэ цэнтэй байх,
- Нутгийн оршин суугчид түүх соёлын өвөөрөө бахархах, түүний үнэ цэнээс орлого хүртэх, хариуцлага хүлээдэг байх,
- Түүх соёлын өвийг ашиглах, хамгаалах, аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөртэй байх,
- Түүх соёлын бүтээгдэхүүний үзмэрээс олсон орлогоос түүнийг хамгаалах, нөхөн сэргээж засварлах зардлын тодорхой хэсгийг хэрэглэгч бүрдүүлдэг байх,

Түүх, соёлын дурсгалын аялал жуулчлалын цогцолбор байгуулж хөгжүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага:

- Сумын төвийн газрыг шинэчлэн зохион байгуулах, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эртний хотын дүр төрхөд нийцүүлэн аялал жуулчлал бүхий суурин газрын олон улсын стандартын чиг хандлагад нийцүүлэх, гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох,
- Хархорины түүх соёлын дурсгалын аялал жуулчлалын цогцолбор нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий эд өлгийн болон оюуны үнэт зүйлсийг бүрэн илэрхийлж чадахаар байх,
- Түүх соёлын дурсгалын аялал жуулчлалын цогцолборын барилга, байгууламж нь уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал архитектурын чуулгын түвшинд хийгдэж гадна дотнын жуулчид, одоогийн болон ирээдүй хойч үе маань түүнийг гайхан биширч, сэтгэл, оюуны таашаал авч байх,
- Түүх, соёлын дурсгалын аялал жуулчлалын цогцолбор нь ЮНЕСКО-гийн түүх соёлын өвийн бүртгэлд тэнцэхүйц түвшинд баригдсан байх,

Монголын түүх, соёлын үнэ цэнэ, амьдралын хэв маягийн онцлог ялгаатай байдлыг илэрхийлж чадахуйц байх,

1. Чингис хааны цогцолбор

Чингис хааны төрсөн газар, хааны суудалд өрсөлдөж хамаг Монголын хаанд өргөмжлөгдсөн, Монгол аймгуудыг нэгтгэж Их Монгол улсыг байгуулж Онон мөрний эхэнд Чингис хаанд өргөмжлөгдсөн, аян дайнд явж Монголын эзэнт гүрнийг /империйг/ байгуулсан, үр хүүхдэдээ газар нутгаа хуваарилсан зэрэг голлох үйл явдлыг харуулсан цогцолборыг Нууц товчоо болон бусад эх сурвалжийг үндэслэн цаг, хугацаа, он дарааллын хэлхээнд болсон үйл явдал, төрт ёс, эв нэгдэл, ялгуулсан алдар суу, хүндэтгэлийг тухайн цаг үеийн нийгэм, соёл, амьдралын хэв маяг, зан үйлийн дүрслэл, уран барилга, баримал байдлаар илэрхийлсэн иж бүрэн цогцолбор байна.

Цогцолборт хамаарах газар нутаг нь тэнгэр эрхэс, ид шидийн орон, хүч чадал төвлөрсөн газар болохыг сүсэг бишрэл, итгэл үнэмшлээр харуулж чадахуйц био энергийн дэлхийн төв байх хэмжээнд байхаар дүрслэн харуулна. Монголчуудын хувьд агуу их мөргөл, тахилга, энергийн төв газар, дэлхийн хэмжээнд Чингис бол Монголынх гэдгийг маргаангүйгээр нотолсон, тунхагласан өрсөлдөх чадвар бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн байна. Их Монгол Улсын газрын зураг, Монголын импер байгуулсан газар нутгийн зургийг үйл явдлын ерөнхий агуулгатай нь үзүүлнэ.



Их эзэн Чингис хааны цогцолбор, түүний бүрэлдэхүүн хэсэг, үндсэн элементүүд

Бүрэлдэхүүн хэсэг	Элементүүд	Байршил	Солбицол		
			х	у	
Тэмүүжин төрсөн газар, бага, идэр настай холбоотой дэд цогцолбор	Төрсөн гэр, үүнтэй холбоотой бодит мэдээлэл, үйл явдал, домог, мифологид үндэслэсэн архитектурын өвөрмөц шийдэл бүхий уран барилга, байгууламж	Хэнтий аймгийн Дадал сумын Онон голын Дэлүүн Болдог хэмээх газар	111° 38' 45.385" E	49° 1' 46.721" N	
	Бага, болон идэр настай холбоотой бодит мэдээлэл, үйл явдал, домог, Бурхан халдун ууланд эрчүүдийн сүлд хиймороо мөргөл, залбирал болон цанын спорт аяллын хосолсон цогцолборын барилга, байгууламж	Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Бурхан халдуны урд зүгт Тэнгэрийн босго даваа даваа хэмээх газарт	109° 3' 31.688" E	48° 37' 30.968" N	
Тэмүүжин Хамаг Монгол аймгийн хаанаар 1189 онд өргөмжлөгдсөнтэй холбоотой дэд цогцолбор	Хар зүрхний Хөх нүүрт Алтан , Хучир, Сача бэхи, Тайчу зэрэг Хамаг Монголын нөлөө бүхий ноёдын хуралдаан болж, Тэмүжинг 1189 онд Хамаг Монголын хаанд өргөмжилсөн, үйл явдал, домог, мифологид үндэслэсэн архитектурын өвөрмөц шийдэл бүхий уран барилга, байгууламж	Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хар зүрхний Хөх нуур хэмээх газар	108° 56' 48.863" E	48° 1' 21.240" N	
Монгол ноёдын Их хуралдай 1206 онд хуралдаж Их Монгол улс байгуулж Тэмүжин хааныг Их Хаан Чингис хаанаар өргөмжилсөнтэй холбоотой дэд цогцолбор	Тэмүүжин бусад аймаг, овгийн байлдан дагуулж нэгтгэж эхэлсэн үйл явдал, домог, сүлд тэнгэр, мифологид үндэслэсэн архитектурын өвөрмөц шийдэл бүхий уран барилга, байгууламж	1206: Онон мөрний эхэнд Монгол ноёдын Их хуралдай хуралдаж Их Монгол улс байгуулагдсаныг даяар олонд тунхаглан зарлаж, Тэмүжин ханыг Их Хаан Чингис хаанаар өргөмжлөв.	Хэнтий аймгийн Батширээт сумын төв	110° 09' 05.613" E	48° 40' 18.187" N

2. Хархорин

Түүх соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх гол нөөцийн нэг нь Хархорин, Эрдэнэ зуу юм. Түүхэн баримт бичигт Хархорин, Эрдэнэ зуугийн талаар дараах эх сурвалжууд бичигдэж үлдсэн байна. Энэ нь Хархорин, Эрдэнэ зууг сэргээн байгуулж, засварлах хөрөнгө оруулалт хийж эдийн засгийн эргэлтэд оруулах асар их боломжийг олгож байна.

Хархорум бол Монголд гэлтгүй дэлхийд гайхагдсан түүхт хот. Их эзэн богд Чингис хаан Их Монгол Улсын нийслэлээр Хархорум хотыг зарлаж дэлхийд тунхагласан. Тухайн цагтаа дэлхийн нийслэлүүдийн нийслэл хот гэгдэж байсан дэлхийд танигдсан хот байв.



Хархорины түүх соёлын дурсгалын цогцолборын архитектурын чуулга, түүний бүрэлдэхүүн хэсэг, үндсэн элементүүд

Бүрэлдэхүүн хэсэг	Элементүүд	Байршил	Солбицол	
			х	у
Өгөөдэй хааны байгуулсан Хархорум хотын эдэлбэр газар болох хааш хаашаа 4 километр урт хэрмийн эргэлтийн цэгийн байгууламж	Хэрмийн эргэлтийн цэгийн 4 өнцөгт хамгаалагч бурхан болох 4 яст мэлхий бүхий сүрлэг чимэглэлийн уран баримал.	Хархорин сумын төвд	Судалгааны ажлын төсөл хэрэгжүүлж байршлыг тогтоох	
Түмэн Амгалант ордны уран барилга, байгууламж	64 багана бүхий тусгайлан зассан өндөр довжоон дээр чулуун суурьтай их танхимтай том ордны уран барилга байгууламж	Эрдэнэ зуугийн хийдийн хашаан дотор	102° 50' 45.03" E	47° 12' 29.79" N
	Ордны үүдэн хэсэгт мөнгөн мод дөрвөн зүг хандуулан байрлуулж дөрвөн лууны амнаас дөрвөн зүйлийн ундаан гоожиж доор нь тоссон мөнгөн савны сүрлэг чимэглэлийн уран баримал			
	Ордны орой дээр нь бишгүүр үлээж буй Виктория охин тэнгэрийн хөшөө бүхий баримал			
Өгөөдэй хаан суурийг нь тавьж Мөнх хааны үед дуусгаж байсан 5 давхар өндөр суварга	Таван давхар өндөр суварга	Хархорин сумын төвд	Судалгааны ажлын төсөл хэрэгжүүлж байршлыг тогтоох	
Олон шашны сүм, хийдийн цогцолбор	Будда, христос, лалын шашны 12 сүм дуганы уран барилга, байгууламж	Хархорин сумын төвд	Судалгааны ажлын төсөл хэрэгжүүлж байршлыг тогтоох	

3. Архелоги, паленталлогийн тусгай цогцолбор

Бүрэлдэхүүн хэсэг	Элементүүд	Байршил	Солбицол	
			х	у
Хагас газар доор, хагас газар дээрх байгууламж	Эртний амьтан, хүмүүсийн хадгалагдан үлдсэн үнэт олдворыг тухайн газартаа байгаа байдлаар нь харуулах, тухайн нутгаас олдсон олдворуудын музей байгуулах	Өмнеговь Баянзаг	Судалгааны ажлын төсөл хэрэгжүүлж байршлыг тогтоох 103° 42' 16.106" E 44° 8' 44.806" N орчимд	

4. Угсаатны соёлын цогцолбор /Цаатан, Дарьганга-Шилийн эрс/

Бүрэлдэхүүн хэсэг	Элементүүд	Байршил	Солбицол	
			х	у
Цаатны ахуй амьдрал, аж байдлыг харуулсан уран барилга, байгууламж	Өгүүлэмжит дурсгалын цогцолбор, музейн барилга	Цагааннуур сумын төв	99° 20' 7.763" E	51° 22' 15.098" N
Дарьгангачуудын ахуй, соёл уран хийц, чимэглэлийн музей, шилийн богд уулын орчим шилийн эрсийн амьдрал-тэмцлийг өгүүлсэн уран баримал, байгууламж	Өгүүлэмжит дурсгалын цогцолбор, музейн барилга	Дарьганга сумын төв	113° 52' 28.343" E	45° 18' 31.928" N

- Хүн амд үзүүлэх рашаан сувиллын тусламж үйлчилгээний зохион байгуулалт, чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр 9-н рашаан сувилалд дэд бүтцийг хөгжүүлэх, тохижуулах төсөл арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

Монгол орон олон улсын рашааны үнэлэмж хангахуйц 90 гаруй ордтойгоос халуун рашааны орд 40, хүйтэн рашааны орд 52, байгалийн халуун уур бүхий орд 1, рашаан төстэй булаг 108, бичил орчин бүхий хүчин зүйлүүд байгаагаас гадна эмчилгээний лаг, наанги шавартай 40 гаруй нуур, шаврын орд газар судлагдсан байна. Одоогоор улсын хэмжээнд ашиглаж байгаа болон цаашид ашиглах 9 рашаан, бүс нутгийн хэмжээнд цаашид ашиглах 3 рашаан, аймгийн хэмжээнд ашиглаж байгаа буюу цаашид ашиглах 18 рашаан, сумын хэмжээнд ашиглаж байгаа буюу цаашид ашиглах 15 рашаан, цаашид ашиглах эмчилгээний нуур болон шаврын орд 12, цаашид савлаж ашиглах рашаан 11 байна.



Рашаан сувиллын аялал жуулчлалын хүрээнд хэрэгжих төсөл, арга хэмжээ

№	Хөгжлийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт	Хэрэгжих төсөл, арга хэмжээ	Хэрэгжих төсөл, арга хэмжээний тооцооллын макро үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт
1	2.2.Хүн амд үзүүлэх рашаан сувиллын тусламж үйлчилгээний зохион байгуулалт, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	Амрагчдын орон байрны багтаамжийг 1-2 дахин нэмэгдүүлэх	Хүчин чадлыг 1-2 дахин нэмэгдүүлэх, байнгын ажиллагаатай болгох	ЭМЯ, БХБЯ	2016-2024 он	бүс бүр өндөр зэрэглэлийн рашаан сувилалтай болж үйлчлүүлэгчиддээ ойртсон байна.
2		1.Баруун бүсэд “Отгон тэнгэр цогцолбор”, Төвийн бүсэд “Шаргалжуут” Говийн бүсэд Дорноговь аймгийн Даланжаргалан суманд “Халзан уул”, Зүүн бүсэд Аварга тосон рашаан сувиллын иж бүрэн цогцолборын бүтээн байгуулалтын төслүүд	9 рашаан сувиллыг хөгжүүлэх барилгажилтын ажлын зураг төсөл хийх	ЭМЯ, БХБЯ,	2016-2024 он	Холбогдох зураг төсөл гарсан байна.
3	2.2.д/байгалийн эмчилгээний нөөц, рашаан сувиллын газруудын кадастр хөтлөх;	Рашаан сувилал бүхий газрын кадастрын үнэлгээ хийх төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх.	Улсын хэмжээнд 90 рашаанд хийнэ.	ЭМЯ, БХБЯ,	2016-2024 он	Рашаан сувилал бүхий газрын кадастрын үнэлгээ хийгдсэн байна.
4	2.3. а/рашаан сувиллын барилга, инженерийн байгууламжид үзлэг хийж рашаан сувиллын дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээ авах /;	Төсөл хэрэгжих рашаан сувиллын газрын 1:2000 масштабтай байр зүйн зураг, газар хөгжүүлэлт, газар ашиглалтын зураг хийх 3. Дорнод аймгийн “Утаат минчүүр “ байгалийн хий, уурын судалгаа- сувиллын төсөл	9 рашаан сувиллын байр зүй, газар ашиглалт, барилгажилт, архитектур, ландшафтын зураг төсөл хийх	ЭМЯ, БХБЯ	2016-2024 он	Холбогдох зураг төсөл гарсан байна.
5		2.Дундговийн Өөш, Говь Алтайн Нар элсэн эмчилгээ, Гурван нуур, Шивэрт, Салбарт, Уньтын Их булаг рашаан сувиллуудын ногоон байгууламж, ландшафтыг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх төслүүд.	9 рашаан сувиллыг хөгжүүлэх барилгажилтын ажлын зураг төсөл хийх	ЭМЯ, БХБЯ,	2016-2024 он	Холбогдох зураг төсөл гарсан байна.
6		цэвэр, бохир, ус, халаалт, цэвэрлэх байгууламж барих барилгажилт, архитектур, ландшафтын зураг төсөл хийх	9 рашаан сувиллыг хөгжүүлэх барилгажилтын ажлын зураг төсөл хийх	ЭМЯ, БХБЯ	2016-2024 он	Холбогдох зураг төсөл гарсан байна.
7	2.3. г/зарим рашаан сувиллын инженерийн шугам сүлжээний засвар үйлчилгээ, бальнотехникийн төхөөрөмжийн шинэчлэлийн асуудлыг судалж, зураг төсөл боловсруулах, шинээр тоноглох.	9 рашаан сувилалд Цэвэр, бохир, ус, халаалт, цэвэрлэх байгууламж барих хот төлөвлөлт, барилгажилтын зураг төсөл хийх	9 рашаан сувиллын инженерийн байгууламжийн зураг төсөл хийх	ЭМЯ, БХБЯ,	2016-2024 он	Холбогдох зураг төсөл гарсан байна.



- Тусгай зориулалтын ан агнуур болон агнуурын бүс нутгийн менежментийн тогтвортой үйл ажиллагааг хангах, агнуурын аялал жуулчлал түүнийг дагалдан хөгжих бусад үйлдвэрлэл, үйлчилгээг кластер хэлбэрээр цогцоор хөгжүүлэх, агнуурын эдэлбэр газрын ГЗБ хийх

Олон улсад олзворын ан агнуурын аялал жуулчлалыг ихэвчлэн ТХГН-ийн зөвшөөрөгдсөн бүс, ан агнуурын статустай ТХГН-т агнуурын аж ахуйг түшиглэн хөгжүүлдэг байна. Манай оронд тул загас барьж тавихаас бусад ан агнуурыг ТХГН-т явуулахыг хориглодог. Агнуурын бүс нутагт нөөцийн судалгаа, менежментийн төлөвлөгөөг үндэслэн явуулдаг.

2012 оноос 2014 оны хооронд нийт 13 аймгийн 49 сумын 62 агнуурын бүс нутгийг агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагаар тогтоолгон аймаг, сумын ИТХ-аас шийдвэр гаргасан. Хуульд зааснаар Монгол улсын нутаг дэвсгэрт зөвхөн эдгээр агнуурын бүс нутагт ахуйн болон тусгай зориулалтаар агнуур хийх юм. Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 93 дугаар тогтоолоор батлагдсан “Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох” журмын 2.4-т тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сумын Засаг дарга, аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагатай тодорхой хугацаагаар гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг “агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч” байхаар заасан. Тус хуулийн хүрээнд 25 нөхөрлөл, орон нутгийн 7 төрийн бус байгууллага, 12 аж ахуйн нэгж нийт 62 агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулан гурвалсан гэрээгээр ажиллаж байна. Үүнээс нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага хамтран 9 агнуурын бүс нутгийн менежментийг, орон нутгийн 7 төрийн бус байгууллага 15 агнуурын бүс нутгийн менежментийг, 11 аж ахуйн нэгж 25 агнуурын бүс нутгийн менежментийг, 14 нөхөрлөл 13 агнуурын бүс нутгийн менежментийг тус тус хариуцан ажиллахаар сумдын Засаг дарга, аймгийн Байгаль орчны газартай гурвалсан гэрээ байгуулсан. Нийт 62 агнуурын бүс нутгаас одоогоор 26 агнуурын бүс нутаг менежментийн төлөвлөгөөг хараахан хэрэгжүүлж эхлээгүй байна.

Тусгай зөвшөөрөлтэй ангийн бүс, нөөц /БОАЖЯ, Байгаль орчны мэдээллийн сан/


Аймаг сум	Ангийн бүсийн нэр	ТЗ-тэй ангийн төрөл	Ангийн нөөц /агнуур зохион байгуулалт/	Талбай /га/
Ховд Үенч	Дунд бодонч	Аргаль, Янгир	5 тэх	17870.9
Ховд Алтай	Бодонч	Аргаль, Янгир	Жилд 2 тэх	83713.2
Дорноговь Хатанбулаг	Хутаг уул	Аргаль, Янгир	Жилд 3-4 угалз	82440.2
Ховд Дуут	Балинч	Янгир	Жилд 2-3 тэх	12513.3
Ховд Дуут	Ар хужирт	Янгир	Жилд 2-3 тэх	15458.9
Ховд Мөст	Давст уул	Янгир	Жилд 1-2 тэх	6718.3
Ховд Мөст	Баатар хайрхан	Янгир	Жилд 2-3 тэх	18095.6
Ховд Цэцэг	Хажинга	Янгир	Жилд 3-4 тэх	33786.1
Ховд Цэцэг	Их бэлчир	Янгир	Жилд 1-2 тэх	13425.4
Баян-Өлгий Булган	Индэрт	Янгир		31990.7
Баян-Өлгий Алтай	Цагаан уул	Янгир		25567.5
Баян-Өлгий Толбо	Хүнгүй нуруу	Янгир		59340.1
Баян-Өлгий Сагсай	Арцат уул	Янгир		10550.4
Баян-Өлгий Бугат	Бахлаг	Янгир		19154.4
Баян-Өлгий Цэнгэл	Баян уул	Янгир		12883.7
Говь-Алтай Алтай	Аж богд	Янгир		395985.1
Баянхонгор Хүрээмарал	Чандмань марал	Янгир	Жилд 2-3 тэх	30867.5
Баянхонгор Жаргалант	Далай хархан	Янгир		17390.9
Баянхонгор Жинст	Хавцгай	Янгир	Жилд 1-3 тэх	3693.6
Баянхонгор Баацагаан	Улаан аргалант	Янгир	Жилд 15 тэх	11110.6
Өвөрхангай Нарийнтээл	Тахилгат, Мандаа, Өшгөг	Янгир	Жилд 3-4 тэх	26339.2
Баян-Өлгий Толбо	Зурхайчын нуруу	Аргаль		20019.5
Баян-Өлгий Булган	Улаагчин	Аргаль		39881.0
Баян-Өлгий Улаанхус	Баянзүрх	Аргаль	Жилд 1-2 угалз /2017/	37451.5



Баян-Өлгий Бугат	Төмөрт	Аргаль	Жилд 1-2 угалз /2017/	21020.6
Баян-Өлгийн Буянт	Эзэрлэг	Аргаль	Жилд 1-2 угалз /2017/	36969.3
Баян-Өлгий Дэлүүн	Ахуунт	Аргаль		42043.6
Ховд Мөст	Баатарын нуруу	Аргаль		39545.4
Ховд Цэцэг	Харнууд, Олон хөтөл	Аргаль		45307.3
Хэнтий Дэлгэрхаан	Дэлгэрхаан	Аргаль		49968.9
Хэнтий Баянмөнх	Язаарын уул, Салхит	Аргаль	Жилд 2 угалз /2016/	33215.8
Архангай Хашаат	Их номгон	Аргаль		8492.7
Сүхбаатар Түвшинширээ	Дэлгэрхаан	Аргаль	Жилд 1-2 угалз	50636.7
Сүхбаатар Баяндэлгэр	Буйлс-Нүдэн	Аргаль	Жилд 1-2 угалз /2018/	119913.7
Говьсүмбэр Сүмбэр	Хээнцийн уул, Сүмбэр	Аргаль	2 угалз	56385.6
Баянхонгор Галуут	Булагийн нуруу	Аргаль	Жилд 1 угалз, 2тэх	24650.5
Баянхонгор Өлзийт	Баян бийр	Аргаль	Жилд 1 угалз	22182.6
Баянхонгор Жинст	Жинст хайрхан	Аргаль		20861.5
Баянхонгор Богд	Ар хуурай, Дулаан	Аргаль	Жилд 1 угалз	26741.0
Баянхонгор Баянцагаан	Баянцагаан	Аргаль	Жилд 1 угалз	10699.3
Дундговь Гурвансайхан	Гурвансайхан	Аргаль		50172.1
Дорноговь Өргөн	Аргалын уул	Аргаль	Жилд 2-3 угалз /2017/	64370.1
Өвөрхангай Богд	Өөш манхан	Аргаль	Жилд 3 угалз /2017/	41911.7
Дорноговь Мандах	Таван баян	Аргаль	2 угалзын нөөцтэй	33041.6
Дорноговь Хөвсгөл	Олон овоот	Аргаль		24882.8
Дорноговь Хатанбулаг	Хатны булаг	Аргаль	6 угалзын нөөцтэй	99589.4
Завхан Шилүүстэй	Цахир, Мандалт	Аргаль	Жилд 2-3 угалз /2018/	45740.2
Төв Өндөрширээт	Уянга- Их зөөлөн-Бага зөөлөн	Аргаль	4-6 Угалз байна	99284.5
Төв Бүрэн	Бүрэнгийн нуруу	Аргаль	Жилд 2 угалз /2019/	33259.4
Төв Алтанбулаг	Алтанбулаг	Аргаль, Буга	Жилд 1-2 угалз, 2-3 дайр	148324.3
Төв Баян-Өнжүүл	Хойд өнжүүл	Аргаль, Буга	Жилд 3-4 угалз, 8-10 дайр	5110.1
Төв Баян-Өнжүүл	Ханан баян	Аргаль, Буга	Жилд 1-2 угалз	108445.0
Төв Лүн	Хангай-Хушигийн нуруу	Аргаль, Буга		47355.8
Төв Өндөрширээт	Урд нуруу, Монгол элс	Буга	5-8 Буга	79865.8
Баян-Өлгий Цэнгэл	Мухар	Буга		30243.3
Баян-Өлгий Булган	Жаргалант	Буга		22847.1
Архангай Ихтамир	Их тамир	Буга		66150.2
Архангай Цэцэрлэг	Хонхорт	Буга		21465.4
Хэнтий Өмнөдэлгэр	Тэнүүн	Гахай	Жил бүр 7-9гахай	87060.3
Хэнтий Цэнхэрмандал	Их буурал	Гахай	Жил бүр 3-4 гахай	28717.2
Хэнтий Батширээт	Хавтгар	Гахай	Жилд 1-2 гахай, 8-10гөрөөс	51723.0
Хэнтий Батширээт	Навчит хайрхан	Гахай		9814.8
Хэнтий Батширээт	Улаан хөндий	Гахай	1-2гахай, 7-9 гөрөөс	44509.2
Хэнтий Дадал	Цээнэтэй	Бор гөрөөс, Гахай	Жилд 1-2 гөрөөс	13101.3
Хэнтий Дадал	Агац гилбэр	Бор гөрөөс, Гахай	Жилд 2-3 гөрөөс, 1-2 гахай	27786.1
Архангай Жаргалант	Хөндлөн уул	Бор гөрөөс		6855.0
Архангай Төвшрүүлэх	Хойд овоо	Бор гөрөөс		5739.4
Архангай Булган	Их ар	Бор гөрөөс		8398.9
Хэнтий Цэнхэрмандал	Ногоон нуруу	Бор гөрөөс	Жилд 4-5 гөрөөс	52466.1
Хэнтий Өмнөдэлгэр	Элгэн жаргалант	Бор гөрөөс	Жилд 8-11 гөрөөс	139673.0
Хэнтий Биндэр	Биндэр	Бор гөрөөс	Жилд 2-3 гөрөөс	42681.0
Хэнтий Батширээт	Арангатай	Бор гөрөөс	Жилд 5-7 гөрөөс	6471.4
Хэнтий Батширээт	Гурван даваа	Бор гөрөөс	Жилд 2-3 гөрөөс	18806.9
Хэнтий Батширээт	Ононгийн арал	Шувуу		4142.2
Хэнтий Батширээт	Номгон	Шувуу		9419.4
Дүн				3237446.7



Тусгай зөвшөөрөлтэй олзворын болон спорт агнуурын нөөц, ангийн бүс




Уул уурхай, дэд бүтэц зэрэг хөгжлийн төслүүд зэрлэг амьтны тархац нутаг, холбоос нутгийг хамарч тэдгээрийн нүүдэллэх, шилжих хөдөлгөөн, үржилд орох, төллөх, сүрэглэх зэрэг амьдрах орчны газар нутгийг таслах, дайжин дүрвэж хорогдох зэрэг сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд олзворын ангийн нөөцөд суурилсан аялал жуулчлалд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа тул ангийн бүс нутагтай давхцал бүхий уул уурхайн лицензтэй газруудад судалгаа хийж салбар дундын зохицуулалт хийх арга хэмжээг төлөвлөсөн. /АМГТХЭГ-с 2018 оны 09 сарын 10-ний өдөр ирүүлсэн тоон зурагт үндэслэн тооцсон/

Ангийн бүс нутгийн уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй газартай давхцсан байдал

Аймаг сум	Ангийн бүсийн нэр	Талбай /га/	Үүнээс УУ-н лицензтэй давхцсан		
			Ашиглалтын	Хайгуулын	%
Баян-Өлгий Толбо	Сайр уул	23140.7		450.7	1.9
Ховд Уенч	Дунд бодонч	17870.9			
Ховд Алтай	Бодонч	83713.2	160.7	18152.6	21.9
Дорноговь Хатанбулаг	Хутаг уул	82440.2	371.8	2809.4	3.9
Ховд Дуут	Балинч	12513.3		2168.8	17.3
Ховд Дуут	Ар хужирт	15458.9			
Ховд Мөст	Давст уул	6718.3			
Ховд Мөст	Баатар хайрхан	18095.6			
Ховд Цэцэг	Хажинга	33786.1			
Ховд Цэцэг	Их бэлчир	13425.4	456.6	2082.8	18.9
Баян-Өлгий Булган	Индэрт	31990.7		3063.6	9.6
Баян-Өлгий Алтай	Цагаан уул	25567.5			
Баян-Өлгий Толбо	Хүнгүй нуруу	59340.1		3.4	0.01
Баян-Өлгий Сагсай	Арцат уул	10550.4		9709.4	92.0
Баян-Өлгий Бугат	Бахлаг	19154.4	351.2	1668.6	10.5
Баян-Өлгий Цэнгэл	Баян уул	12883.7			

Говь-Алтай Алтай	Аж богд	395985.1	340.8	121485.8	30.8
Баянхонгор Хүрээмарал	Чандмань марал	30867.5		22942.5	74.3
Баянхонгор Жаргалант	Далай хархан	17390.9			
Баянхонгор Жинст	Хавцгай	3693.6			
Баянхонгор Баацагаан	Улаан аргалант	11110.6			
Өвөрхангай Нарийнтээл	Тахилгат, Мандаа, Өшгөг	26339.2		1622.4	6.2
Баян-Өлгий Толбо	Зурхайчын нуруу	20019.5			
Баян-Өлгий Булган	Улаагчин	39881.0			
Баян-Өлгий Улаанхус	Баянзүрх	37451.5			
Баян-Өлгий Бугат	Төмөрт	21020.6			
Баян-Өлгийн Буянт	Эзэрлэг	36969.3		19308.7	52.2
Баян-Өлгий Дэлүүн	Ахуунт	42043.6		454.5	1.1
Ховд Мөст	Баатарын нуруу	39545.4			
Ховд Цэцэг	Харнууд, Олон хөтөл	45307.3		14149.5	31.2
Хэнтий Дэлгэрхаан	Дэлгэрхаан	49968.9	25.4		0.1
Хэнтий Баянмөнх	Язаарын уул, Салхит	33215.8			
Архангай Хашаат	Их номгон	8492.7			
Сүхбаатар Түвшинширээ	Дэлгэрхаан	50636.7		21327.8	42.1
Сүхбаатар Баяндэлгэр	Буйлс-Нүдэн	119913.7			
Говьсүмбэр Сүмбэр	Хээнцийн уул, Сүмбэр	56385.6		6146.4	10.9
Баянхонгор Галуут	Булагийн нуруу	24650.5	69.5	14707.2	59.9
Баянхонгор Өлзийт	Баян бийр	22182.6			
Баянхонгор Жинст	Жинст хайрхан	20861.5			
Баянхонгор Богд	Ар хуурай, Дулаан	26741.0			
Баянхонгор Баянцагаан	Баянцагаан	10699.3		874.9	8.2
Дундговь Гурвансайхан	Гурвансайхан	50172.1	75.3	5798.6	11.7
Дорноговь Өргөн	Аргалын уул	64370.1		8727.2	13.6
Өвөрхангай Богд	Өөш манхан	41911.7			
Дорноговь Мандах	Таван баян	33041.6	4731.1	20223.5	75.5
Дорноговь Хөвсгөл	Олон овоот	24882.8	4234.8		17.0
Дорноговь Хатанбулаг	Хатны булаг	99589.4	275.9	13511.7	13.8
Завхан Шилүүстэй	Цахир, Мандалт	45740.2		3540.2	7.7
Төв Өндөрширээт	Уянга- Их зөөлөн-Бага зөөлөн	99284.5		8443.3	8.5
Төв Бүрэн	Бүрэнгийн нуруу	33259.4		2454.6	7.4
Төв Алтанбулаг	Алтанбулаг	148324.3			
Төв Баян-Өнжүүл	Хойд өнжүүл	5110.1			
Төв Баян-Өнжүүл	Ханан баян	108445.0	1497.0	1919.8	3.2
Төв Лүн	Хангай-Хушигийн нуруу	47355.8	140.6		0.3
Төв Өндөрширээт	Урд нуруу, Монгол элс	79865.8			
Баян-Өлгий Цэнгэл	Мухар	30243.3	705.9	87.1	2.6
Баян-Өлгий Булган	Жаргалант	22847.1	410.4	951.9	6.0
Архангай Ихтамир	Их тамир	66150.2			
Архангай Цэцэрлэг	Хонхорт	21465.4			
Хэнтий Өмнөдэлгэр	Тэнүүн	87060.3			
Хэнтий Цэнхэрмандал	Их буурал	28717.2			
Хэнтий Батширээт	Хавтгар	51723.0			
Хэнтий Батширээт	Навчит хайрхан	9814.8			
Хэнтий Батширээт	Улаан хөндий	44509.2			
Хэнтий Дадал	Цээнэтэй	13101.3			
Хэнтий Дадал	Агац гилбэр	27786.1			
Архангай Жаргалант	Хөндлөн уул	6855.0			
Архангай Төвшрүүлэх	Хойд овоо	5739.4			
Архангай Булган	Их ар	8398.9			
Хэнтий Цэнхэрмандал	Ногоон нуруу	52466.1	627.3	73.2	1.3
Хэнтий Өмнөдэлгэр	Элгэн жаргалант	139673.0	740.9	105.0	0.6
Хэнтий Биндэр	Биндэр	42681.0	480.7		1.1
Хэнтий Батширээт	Арангатай	6471.4	470.9		7.3
Хэнтий Батширээт	Гурван даваа	18806.9			
Хэнтий Батширээт	Ононгийн арал	4142.2			
Хэнтий Батширээт	Номгон	9419.4			
Дүн		3237446.7	16166.9	328965.3	10.7







Таних тэмдэг

- Төлөвлөж буй тээвэр ложистикийн цогцолбор төв
- Төлөвлөж буй авто тээврийн үйлчилгээний цогцолбор төвүүд
- Сумын төв
- Аймгийн төв
- ◎ Хилийн боомт
- † Агаарын тээврийн зориулалтаар ашиглагдаж буй газрын байршил
- Улсын хил
- Аймгийн хил
- МУ-н хатуу хучилттай авто замын сүлжээ
- Одоо баригдаж байгаа хатуу хучилттай авто зам
- МУ-н төмөр замын сүлжээ
- 2016-2020 онд барихаар төлөвлөж буй хатуу хучилттай авто зам
- 2020 оноос хойш барихаар төлөвлөж буй хатуу хучилттай авто зам
- Төлөвлөж буй ОУ-н хурдны зам
- Төлөвлөж буй тусгай зориулалтын авто зам
- Төлөвлөж буй ЗГ-с трасс нь баталгаажсан төмөр зам
- Төлөвлөж буй төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогод тусгагдсан төмөр зам
- ТЭЗҮ хийгдсэн төмөр замын трасс /хувилбар/

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018 - 2025 он/ Зам, тээврийн газрын УГЗБЕТ-ний схем зураг



- Эдийн засгийн бүсүүд**
- Төвийн бүс
 - Зүүн бүс
 - Баруун бүс
 - Хангайн бүс
 - Улаанбаатарын бүс



Дорноговь аймгийн Сайншанд сумаас Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум хүртэл төлөвлөсөн төмөр замын трасс

4. Зам, шугам сүлжээний газрын УГЗБЕТ-ний төсөл арга хэмжээ


Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 23,6% нь авто болон төмөр замын зориулалтаар ашиглахад нэн хүндрэлтэй нөхцөлтэй, 27,5% хүндрэлтэй нөхцөлтэй, 48,9% хэвийн нөхцөлтэй гэсэн ерөнхий үнэлгээ гарч байна.

Авто болон төмөр замын зориулалтаар ашиглаж болох газрын нэгдсэн үнэлгээ

	Үнэлгээний зэрэглэл	Талбай, км ²	Эзлэх, %
1	Нэн хүндрэлтэй	369369,1	23,6
2	Хүндрэлтэй	431412,9	27,5
3	Хэвийн	765818,0	48,9

Газрын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн боловсруулсан замын сүлжээний газрын ГЗБЕТ нь Монгол улсад зам барьж байгуулах шийдэл гаргах, замын сүлжээний оновчтой байршил, замналыг тогтоох газар сонгох, зураг төсөл ТЭЗҮ боловсруулах, төсөвт өртгийг тооцох, шинжлэх ухааны туршилт-үйлдвэрлэл эрхлэх, зам арчлалтын төлөвлөлт, менежментийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын төсөөллийг тооцоход суурь үндэслэл болж өгнө.

Авто болон төмөр замын зориулалтаар ашиглаж болох газрын нэгдсэн үнэлгээ



АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ

Монгол Улсын зам, тээврийн сүлжээний өнөөгийн байдал

Монгол улс хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд авто замыг хөгжүүлэхэд оруулсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг үр дүнтэй ашиглах, Азийн авто замын сүлжээнд аль болох түргэн холбогдох асуудалд сүүлийн жилүүдэд онцгой анхаарч авто замын сүлжээ хурдацтай өргөжиж байна.

Монгол улсад улсын чанартай 12967км зам байгаа бөгөөд үүнээс 4333км нь олон улсын чанартай авто зам байна. Орон нутгийн чанартай 36540км замтай бөгөөд Үндэсний авто

замын сүлжээ 49507км байна. 2016 оны эцсээр хатуу хучилттай замын сүлжээ 6234.85 км болсон байна. Мөн баригдаж буй хатуу хучилттай авто зам 973.26км байна. /ЗТХЯ-с/

Монгол Улсын авто замын нягтрал

Эдийн засгийн бүс	Нийт нутаг дэвсгэр. кв.км	Хатуу хучилттай зам.км	Хатуу хучилттай замын нягтрал. км	
			1 кв.км	1000 кв.км
Нийт дүн	1564144.29	8804.1	0.0056	5.63
Баруун бүс	415254.00	2599.4	0.0063	6.26
Баян-Өлгий	45704.89	232.1	0.0051	5.08
Говь-Алтай	141447.67	339.3	0.0024	2.40
Завхан	82455.67	476.7	0.0058	5.78
Увс	69585.39	435.5	0.0063	6.26
Ховд	76060.38	1115.7	0.0147	14.67
Хангайн бүс	384421.30	1866.4	0.0049	4.86
Архангай	55313.82	437.8	0.0079	7.91
Баянхонгор	115977.80	282.0	0.0024	2.43
Булган	48761.53	397.5	0.0082	8.15
Өвөрхангай	62895.33	397.9	0.0063	6.33
Хөвсгөл	100628.82	298.9	0.0030	2.97
Орхон	844.00	52.2	0.0619	61.89
Төвийн бүс	473554.89	2766.2	0.0058	5.84
Дорноговь	109472.30	636.4	0.0058	5.81
Дундговь	74690.32	246.8	0.0033	3.30
Өмнөговь	165380.47	622.5	0.0038	3.76
Сэлэнгэ	41152.63	346.4	0.0084	8.42
Төв	74042.37	712.4	0.0096	9.62
Дархан-Уул	3275.00	104.6	0.0319	31.93
Говьсүмбэр	5541.80	97.2	0.0175	17.54
Зүүн бүс	286209.65	714.1	0.0025	2.50
Дорнод	123597.43	155.9	0.0013	1.26
Сүхбаатар	82287.16	212.1	0.0026	2.58
Хэнтий	80325.06	346.1	0.0043	4.31
Улаанбаатарын бүс	4704.45	858.0	0.1824	182.38

1. Уул уурхайн замуудыг нэмж тооцсон.

2. Зөвхөн Улаанбаатарын бүсэд хот суурин доторх хатуу хучилттай авто замыг нэмж тооцсон.

Замын нягтрал АНУ-д 1000 кв.км газарт 600км, Канад улсад 1000 кв.км газарт 300км, ОХУ-д 1000 кв.км газарт 60 км хатуу хучилттай зам тус тус ногдож байгаа бол Монгол улсад 1000 кв.км газарт 5.63 км хатуу хучилттай зам ногдож байгаа бөгөөд хоногийн дундаж эрчим нь доорх байдалтай байна.



Монгол Улсын авто замын сүлжээний эрчим /ЗТХЯ-с/



ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Замын сүлжээний газрын кадастр хийх, замын доорх төрийн өмчийн газрыг эд хөрөнгийн хэлбэрт шилжүүлж үнэлэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, замын үнэ цэнийг нэмэгдүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг шийдвэрлэх, Ашигт малтмал, газрын тосны тээвэрлэлт нь ихэнх тохиолдолд зам, шугам сүлжээний ангилалд шилжээгүй, зам баригдаагүй газраар тээвэрлэгдэж бэлчээрийн газрыг элэгдэл, эвдрэлд оруулж, хүрээлэнд буй орчинд сөрөг нөлөө үзүүлж цөлжилтөд нөлөөлж, иргэд, малчдын эрх ашгийг хөндсөн хэвээр байгаа боловч төрийн өмчийн газар, байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн асуудал орхигдож байгаа асуудлыг шийдвэрлэх
- Нэгдүгээр үе шат 2017-2020: Нэн тэргүүн ээлжид хэвтээ тэнхлэгийн замын сүлжээг барьж дуусгаж аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар нийслэлтэй холбох, ХАА-н бүтээгдэхүүний экспортын ойрын ирээдүй, зах зээлийн боломж, улс бүс нутгийн чанартай рашаан сувилал, аялал жуулчлалын зам тээврийн нөхцөлийг эн тэргүүнд сайжруулах хэрэгцээ, шаардлагыг харгалзан тусгай зориулалтын болон олон улсын болон улсын чанартай замуудыг барих
- Хоёрдугаар үе шат 2020-2024 он: Эдийн засгийн бүс, бүс хоорондын босоо тэнхлэгийн замыг барих ажлыг эрчимжүүлэх, бүс доторх болон бүс хооронд аймгийн төвүүдийг хатуу хучилттай замаар холбож, бүсүүдийн дотоод болон бүс хоорондын нийгэм, эдийн засгийн харилцааны таатай орчныг бүрдүүлэх, олон улс хоорондын зам тээврийн сүлжээтэй нэгдэж холбогдох, хил залгаа орнуудын бүс нутаг, мужуудтай хамтын ажиллагаа, зах зээлийн харилцаанд оролцох хилийн боомтуудыг ойролцоох аймаг, сумын төвүүд, хэвтээ босоо тэнхлэгийн замуудтай холбохоор төлөвлөв. /ЗТХЯ-тай хамтран боловсруулав/



Авто замын газрын төлөвлөлт



Улсын ГЗБЕТ-ний хэрэгжилтийн эхний үе шатанд баригдах авто зам

Авто замын чиглэл	Авто замын сүлжээгээр холбогдох замнал /холбогдох хот, суурин, ордууд, хатуу хучилттай замын нэр/	Замын ангилал, зориулалт	Хэрэгжих хугацаа	Хэмжээ /км/	Замын ангилалд шилжих газар. га
Олон улсын чанартай авто зам					
*Дорнод.Хэрлэн-Баянхошуу	Дорнод аймгийн төв Хэрлэн сум-Баянхошуу боомт	Олон улсын чанартай авто зам	2016-2020	323	3230
*Дорнод.Хэрлэн сум-Хавиргын боомт	Хэрлэн сум-Хавиргын боомт	Олон улсын чанартай авто зам	2016-2020	132	1320
*Хэрлэн-Эрээнцав	Дорнод аймгийн Хэрлэн сум-Энгэр шанд-Эрээнцав	Олон улсын чанартай авто зам	2016-2020	181	1810
*Даланзадгад-Шивээхүрэн боомт	Даланзадгад-Баяндалай-Гурвантэс-Шивээ хүрэн	Олон улс, улсын чанартай уурхай, аялал жуулчлалын зориулалттай авто зам	2016-2020	271	2710
*Баруун-Урт-Бичигт хилийн боомт	Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагаан-Бичигт хилийн боомтой холбох	Олон улсын чанартай авто зам	2016-2020	293	2930
*Хутаг-Өндөр-Бага-Илэнх боомт	Булган аймгийн Хутаг-Өндөр-Тэшиг-Бага-Илэнх боомт	Олон улсын чанартай авто зам	2016-2020	138	1380
*Есөнбулаг-Бургастай	Есөнбулаг-Шарга-Төгрөг-Бугат-Бургастай боомт	Олон улсын чанартай авто зам	2016-2020	331	3310
Төлөвлөж буй олон улсын чанартай авто замын дүн				1669	16690



Хэвтээ, босоо тэнхлэгийн улсын чанартай авто зам						
*УБ-Булган-Мөрөн	Дашинчилэн-Орхон сум-Булган аймгийн төв.	Хэвтээ чиглэлийн улсын чанартай авто зам	2016-2020	124	1240	
*Чойбалсан-Рашаант	Дорнод.Чойбалсан-Халхгол-Рашаант боомт	Хэвтээ тэнхлэгийн олон улсын болон улсын чанартай авто зам	2016-2024	Хэрлэн-Баянхошуу чиглэлийн замаас-153	1530	
*Ховд-Улаангом-Боршоо	Ховдын аймгийн Мянгад-Увс. Өлгий сум-Төв зам /шар бүрд/	Босоо тэнхлэгийн улсын чанартай авто зам	2016-2020	160	1600	
*Алтай-Улиастай	Говь-Алтай.Есөнбулаг-Завхан. Улиастай	Босоо тэнхлэгийн аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	186	1860	
*Мөрөн-Ханх хилийн боомт	Хатгал-Ханх	Босоо тэнхлэгийн олон улс, улс, тусгай зориулалтын/ аялал жуулчлал/ зам	2016-2020	180	1800	
*Тэрхийн цагаан нуур-Мөрөн	Тэрхийн цагаан нуур-Ороохын даваа-Жаргалант- Шинэ-Идэр-Мөрөн	Аялал жуулчлал, цаашдаа Ханхын хилийн боомттой холбох улсын чанартай авто зам.	2016-2020	217	2170	
Төлөвлөж буй улсын чанартай авто замын дүн				1020	10200	
Тусгай зориулалтын авто зам						
*УБ-Хөшигтийн хөндий	УБ-Хөшигтийн хөндий	улсын чанартай хурдны зам	2016-2020	23	230	
*УБ-Даланзадгад-Цогтцэций	Өмнөговь.Цогтцэций сумын төвийг Улаанбаатар Даланзадгадын төв замтай холбох.	Орд газрын тусгай зориулалтын авто зам	2016-2020	55	550	
*Хялганат-Эрдэнэт	Хялганат-Хангал-Эрдэнэт	Үйлдвэрийн тусгай зориулалтын авто зам	2016-2020	58	580	
*Дархан-Шарын гол	Дархан-Шарын гол	Уурхайн тусгай зориулалтын авто зам	2016-2020	48	480	
*УБ-Жанхай-Тойлогт	Хатгал-Жанхай-Тойлогт	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай авто зам	2016-2020	33	330	
*УБ-Өндөрхаан-Дадал	Хэнтий.Өндөрхаан-Батноров-Норовлин-Дадал	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай авто зам	2016-2020	250	2500	
*Зүүнбаян-Хамрын хийд	Сайншанд-Хамрын хийдийн замаас Зүүнбаян	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай авто зам	2016-2020	20	200	
Завхан.Улиастай-Отгонтэнгэрийн рашаан сувилал, амралт	Завхан.Улиастай-Отгонтэнгэрийн рашаан сувилал, амралт*	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2016-2020	85	850	
Алтай-Ховд	Алтай-Ховдын төв зам-Хар ус нуур*	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2016-2020	8	80	
Төлөвлөж буй тусгай зориулалтын авто замын дүн				2016-2020	580	5800
2016-2020 онд барихаар төлөвлөж буй авто замын нийт дүн				3269	32690	



Улсын ГЗБЕТ-ний хэрэгжилтийн хоёрдугаар үе шатанд баригдах авто зам*

Авто замын чиглэл	Авто замын сүлжээгээр холбогдох замнал. /холбогдох хот, суурин, ордууд, хатуу хүчилттай замын нэр/	Замын ангилал, зориулалт	Хэрэгжих хугацаа	Хэмжээ /км/	Замын ангилалд шилжих газрын хэмжээ,га
Олон улсын чанартай авто зам					
Алтанбулаг-Замын-Үүд	Алтанбулаг-Багахангай-Замын –Үүд	Олон улсын транзит тээврийн хурдны авто зам /хаалт хамгаалалттай/	2020-2024	997	9970
Өндөрхаан-Ульхан боомт	Өндөрхаан-Норовлин-Баян-уул-Ульхан боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	72	720
Чойбалсан-Ульхан боомт	Чойбалсан-Баян-Уул-Ульхан боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	240	2400
Өлгий-Даян боомт	Өлгий-Сагсай-Даян боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	175	1750
Шаамар-Зэлтэрийн боомт	Шаамар-Зүүн бүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	112	1120
Зүүнбаян-Ханги боомт	Зүүнбаян-Хөвсгөл-Хатанбулаг-Ханги боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	225	2250
Ханбогд-Ханги боомт	Ханбогд-Хатанбулаг	Олон улсын чанартай авто зам	2020-2024	258	2580
Арвайхээр- Шивээ хүрэн боомт	Арвайхээр- Гучин-ус-Богд-Гурвантэс-Шивээ хүрэн боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	424	4240
Баянхонгор- Шивээхүрэн боомт	Баянхонгор-Богд-Баянлиг-Гурвантэс-Шивээхүрэн боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	285	2840
Цагааннуур-Улаангом	Цагааннуур- Улаан даваа-Улаангом	Олон улсын чанартай авто зам	2020-2024	193	1930
Улиастай-Арц суурь боомт	Завхан.Улиастай-Арц суурь боомт	Олон улсын чанартай авто зам	2020-2024	181	1810
Төлөвлөж буй олон улсын чанартай авто замын дүн			2020-2024	3162	31620
Улсын чанартай авто зам					
Мөрөн- Улиастай	Мөрөн-Дөрвөн замын уулзвар	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	238	2380
Улиастай-Ховд	Улиастай-Дөргөн-Мянгад	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	381	3810
Баруун-Урт- Чойбалсан	Баруун-Урт- Чойбалсан	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	183	1830
Сайншанд- Баруун-Урт	Сайншанд-Дэлгэрэх-Түвшинширээ-Уулбаян- Баруун-Урт	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	328	3280
Мандалговь- Арвайхээр	Мандалговь-Цагаан-Овоо нүүрсний уурхай-Эрдэнэдалай-Сант-Арвайхээр	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	282	2820
Мандалговь- Сайншанд	Мандалговь-Их газрын чулуу жуулчны бааз-Хөөтийн хонхорын нүүрсний уурхай-Өндөршил-Сайншанд	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	338	3380
Сүмбэр/Чойр/- Мандалговь	Сүмбэр/Чойр/-Шивээ-Овоо-Говь-Угтаал-Их газрын чулуу жуулчны бааз-Мандалговь	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	184	1840
Сүмбэр/Чойр/- Өндөрхаан	Бор-Өндөр-Дархан-Баянмөнх-Өндөрхаан	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	225	2250
УБ-Мөрөн	Хөвсгөл.Тосонцэнгэл-Архангай. Өгийнуур	Аймаг хоорондын улсын чанартай зам	2020-2024	263	2630
Төлөвлөж буй улсын чанартай авто замын дүн			2020-2024	2422	24220



Тусгай зориулалтын авто зам					
Өгийнуур-Их тамир	Өгийнуур-Батцэнгэл	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	103	1030
Хужирт-Арвайхээр	Хужирт-Арвайхээр	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	66	660
Тавантолгой- Сайншанд	Цогтцэций-Манлай-Мандах-Сайхандулаан- Сайншанд	Үйлдвэр, уурхайн тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	474	4740
Баян-Өлгий-Хар тарвагатайн нүүрсний уурхай	Баян-Өлгий-Увс.Ховд-Өмнөговь-Өлгий сум	Үйлдвэр, уурхайн тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	204	2040
*Даланжаргалан-Бор-Өндөр	Даланжаргалан-Бор-Өндөр	Үйлдвэр, уурхайн тусгай зориулалтын улсын чанартай зам	2016-2020	45	450
Хэнтий.Цэнхэрмандал-Хөх нуур	Хэнтий. Цэнхэрмандал-Хөх нуур	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2016-2024	32	320
Өмнөговь,Даланзадгад-Баянзаг	Өмнөговь. Даланзадгад-Баянзаг	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2016-2020	102	1020
Жаргалтхаан-Аварга тосонгийн рашаан	Хэнтий. Жаргалтхаан-Аварга тосонгийн	Улс, бүсийн чанартай рашаан сувиллын тусгай зориулалтын улсын чанартай зам	2016-2020	41	410
Архангай.Цэцэрлэг-Шивэрт	Архангай. Цэцэрлэг-Шивэрт	Улс, бүсийн зэрэглэлтэй рашаан сувиллын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	23	230
Даланжаргалан-Халзан уулын рашаан	Дорноговь. Даланжаргалан-Халзан уулын рашаан	Улс, бүсийн зэрэглэлтэй рашаан сувиллын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	49	490
УБ-Босго тэнгэрийн даваа	УБ-Багануур-Босго тэнгэрийн даваа	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	108	1080
Төв зам-Шаргалжуут	Төв зам-Шаргалжуут	Улс, бүсийн зэрэглэлтэй рашаан сувиллын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	51	510
Мөрөн-Цагааннуур сум	Мөрөн-Хатгалын замаас-Цагааннуур сумын төв	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	201	2010
Өлгий-Даянгийн боомт	Өлгий-Даянгийн боомтын замаас-Цэнгэл сумын төв	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	16	160
Хэрлэн-Эрээнцав	Хэрлэн-Эрээнцавын замаас-Утаат минчүүр /байгалийн уурын рашаан	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	10	100
Тэрхийн цагаан нуур-Жаргалант	Хөвсгөл.Жаргалант-Галт-Салбарт / Рашаан	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам /	2020-2024	65	650



Ховд-Дуут	Дуут сум-Нэвт рашаан	Улс, бүсийн зэрэглэлтэй рашаан сувиллын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	10	100
Улаангом-Увс нуур	Улаангом-Увс нуур	Аялал жуулчлалын тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	27	270
Оюу толгой-Ханбогд	Оюу толгой-Ханбогд	тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	36	360
Бичигт боомт-Баянхошуу боомт	Бичигт боомт-Баянхошуу боомт	тусгай зориулалтын улсын чанартай зам	2020-2024	345	3450
Төлөвлөж буй тусгай зориулалтын авто замын дүн				2008	20080
2020-2024 онд барихаар төлөвлөж буй авто замын нийт дүн				7592	75920

Улсын ГЗБЕТ-ний хэрэгжилтийн үе шатанд уул уурхай, ХАА-н хөгжлийг дэмжих чиглэлээр баригдах шаардлагатай тусгай зориулалтын авто замууд

Аймаг, сум	Авто замын сүлжээтэй холбогдох замнал /холбогдох хот, суурин, ордууд, хатуу хучилттай замын нэр/	Тусгай зориулалтын чиглэл	Хэмжээ /км/	Замын ангилалд шилжих газар. га
Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг	Цагаан суварга-Ханги	Уул уурхайн хөгжлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах	167.93	1679.3
Өмнөговь аймгийн Гурвантэс	Торомхон-Гурвантэс-Шивээхүрэн	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	82.05	820.5
Говь-Алтай аймгийн Бугат	Хиагтын сэврээ-Бургастай	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	37.25	372.5
Увс аймгийн Бөхмөрөн	Хотгорын уурхай-Бөхмөрөн-Өлгий	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	37.03	370.3
Говь-Алтай аймгийн Төгрөг	Хүрэн-Төгрөг-Бургастай	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	34.58	345.8
Дундговь аймгийн Гурвансайхан	Хар тойром-Гурвансайхан-Мандалговь	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	26.57	265.7
Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түвшинширээ	Бүрэнцогт-Өлзийт-Уулбаян	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	57.18	571.8
Төв аймгийн Баянжаргалан	Төгрөг-Баян	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	29.21	292.1
Төв аймгийн Баян	Цайдам-Баян-Шивээ овоо	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	24.30	243.0
Дундговь аймгийн Баянжаргалан	Өвдөг худаг-Даланжаргалан	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	40.95	409.5
Дорноговь аймгийн Даланжаргалан	Даланжаргалан-Бор-Өндөр	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	45.51	455.1
Өмнөговь аймгийн Баян-Овоо	Цант-Цогтцэций Гашуунсухайтын зам	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	50.79	507.9
Дорноговь аймгийн Алтанширээ	Эрдэнэцогт-Алтанширээ-Сайншанд	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	69.28	692.8



Дорноговь аймгийн Даланжаргалан	Билүүт-Даланжаргалан	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	11.69	116.9
Дорноговь аймгийн Даланжаргалан	Алаг толгой-Даланжаргалан	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	23.33	233.3
Говь-Алтай аймгийн Цээл	Таяннуур-Бургастай	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	87.53	875.3
Сэлэнгэ аймгийн Зэлтэр сум	Улаан овоогийн уурхайгаас-Зэлтэр боомт ЗТХ-н сайдын 2015.01.16/16 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	18.5	185,0
Дорноговь аймгийн Дэлгэрэх	Чандмань уулын уурхай-Сайншанд/ЗТХ-н сайдын 2017.05.10-н 92 дугаар тушаал, Засгийн газрын 317 дугаар тушаалаар концессын эрх олгосон/	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	131.7	1317,0
Дорноговь аймгийн Мандах сум	Мандах нуурын уурхайгаас Таван толгой-Ханги чиглэлийн замруу ЗТХ-н сайдын 2012.06.22/187 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	69.8	698
Дорноговь аймгийн Хөвсгөл сум	Айлбаянгийн уурхайгаас-Ханги боомтын замруу ЗТХ-н сайдын 2014.10.25/285 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	61.9	619
Дорноговь аймгийн Хатанбулаг сум	Агар уулын уурхайгаас Таван толгой-Ханги чиглэлийн замруу ЗТХ-н сайдын 2012.05.30/158 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	13.9	139
Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Баян-Ундрага уурхайгаас Нарийн сүхайд чиглэлийн замруу ЗТХ-н сайдын 2015.12.18/357 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	17.9	179
Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Баянтэсийн уурхайгаас Нарийн сүхайд-Шивээ хүрэнгийн замруу ЗТХ-н сайдын 2018.02.21/28 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	32.9	329
Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Хүрэн шандын уурхайгаас Нарийн сүхайд-Шивээ хүрэнгийн замруу ЗТХ-н сайдын 2014.09.02/206 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	14.6	146
Өмнөговь аймгийн Баян-Овоо сум	Цант уулын нүүрсний уурхайгаас Ухаа худаг-Гашуун сүхайд чиглэлийн замруу ЗТХ-н сайдын 2011.07.25/202 тушаал	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	38.9	389
Өмнөговь аймгийн Цогтцэций	Таван толгой уурхайгаас-Шинээр нээгдэх Цагаан дэлийн хилийн боомт /ЗГ-ын 2017 оны 277-р тогтоолоор нэмсэн/	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	270	2700,0
Өмнөговь аймгийн Цогтцэций	Таван толгой уурхайгаас- Цагаан суварга-Ханги боомт /Засгийн газрын 317 дугаар тушаалаар концессын эрх олгосон/ 432км /үүнээс 140км Таван толгой-Сайншанд чиглэлийн замаас Цагаан суварга хүртэл/	Уул уурхайн хөгжлийг дэмжих байгаль орчныг хамгаалах	140	1400,0
